



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД,
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: БНА-2020/1/СТА-ТЭЗ

БАЯНХОНГОР АЙМГИЙН ТӨСВИЙН
ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2019 ОНЫ
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор хот 2020 он

Тэргүүлэх аудитор: **Б.Мөнхбат**
Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер **А.Цээням**
Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn
Ахлах аудитор: **Б.Должмаа**
Утас: 88119345 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn
Аудитор: **Г.Ганчимэг**
Утас: 88268424 Цахим хаяг: Ganaa_7133@yahoo.com
Аудитор: **Н.Бүнчинсүрэн**
Утас: 99049866 Цахим хаяг: nbunchin0719@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.Цахим хуудас:
www.audit.mn

АГУУЛГА

Тайланг хянасан:	Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	2
Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар	АУДИТ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ	2
	АУДИТЫН ЗОРИЛТ	2
	АУДИТЫН ХАМАРСАН ХҮРЭЭ	2
	АУДИТЫН АРГА ЗҮЙ	2
Дарга, тэргүүлэх аудитор	АУДИТАД АШИГЛАСАН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	2
Б.Мөнхбат	АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН ХУГАЦАА, АУДИТЫН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН	2
	АУДИТЫН ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ, ТҮҮНД ТУСГАГДСАН МЭДЭЭЛЭЛ, ХЭЛЭЛЦҮҮЛСЭН ЖУРАМ	3
	АУДИТ ХИЙХЭД ГАРСАН ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ	3
	ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	3
Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер	Хүснэгтийн товьёг, хавсралт судалгааны товьёг	4
А.Цээням	Үндсэн мэдээлэл	5
Тайланг бэлтгэсэн:	Гүйцэтгэлийн аудитын дүн	6
Ахлах аудитор	Бүлэг 1. Аймгийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн татварын орлогын төлөвлөгөө аймгийн Татварын хэлтсийн мэдээнээс 9.1 сая, гүйцэтгэл нь 204.5 сая төгрөгөөр зөрүүтэй байна.	6-13
Аудитор	Бүлэг 2. Зардлыг оновчтой төлөвлөөгүйгээс төсвийн жилийн дундуур төсөвт зохицуулалт хийдэг, оны эцэст хэмнэгдсэн зардлыг зохицуулалт хийлгэж зориулалт бусаар зарцуулсан байна.	14-24
	Бүлэг 3. Аудитаар өгсөн зөвлөмжийг аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс биелүүлж ажиллахгүйгээс төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой зөрчлүүд давтагдан гарсаар байна.	25-27
2020 оны 04 дүгээр сарын 24-ны өдөр	АУДИТЫН ДҮГНЭЛТ	28
	АУДИТЫН ЗӨВЛӨМЖ	29-30
	ХАВСРАЛТ СУДАЛГАА	31-36

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70442424 дугаарын утас,
70442584 дугаарын
факсаар харилцана уу.

ХАЯГ:

Баянхонгор аймаг дахь
Төрийн аудитын газар
Аймгийн ЗДТГ-ын байр,
Баянхонгор сум,
Баянхонгор аймаг-64000
Монгол Улс

<p>Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх</p>	<p>Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл</p> <p>Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2019 оны А/100 дугаар тушаалаар батлагдсан “Үндэсний аудитын газрын 2020 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн аудитын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.</p>
<p>Аудитын зорилт</p>	<p>Монгол улсын төсвийн тухай хууль, Баянхонгор аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг шалгаж, дүгнэлт, зөвлөмж гарган аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал болон төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.</p> <p>Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ.</p> <ol style="list-style-type: none"> 1. ТЭЗ-ийн 2019 оны төсвийн орлогыг бодитой төлөвлөж, төвлөрүүлсэн эсэх. 2. ТЭЗ-ийн 2019 оны төсвийн зарлагыг үндэслэлтэй төлөвлөж, зориулалтын дагуу, үр дүнтэй зарцуулж буй эсэх. 3. Өмнөх аудитын зөвлөмжийг биелүүлж ажилласан эсэх.
<p>Аудитын хамарсан хүрээ</p>	<p>Аймгийн ТЭЗ-ийн 2019 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, аймаг, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, аймгийн Татварын хэлтсийн тайлан, Сангийн яамнаас Баянхонгор аймгийн 2019 оны аймгийн төсвийн суурь, орлого зарлагыг хянаж ирүүлсэн тооцоо болон бусад материалд тулгуурлан аудитыг гүйцэтгэв.</p>
<p>Аудитын арга зүй</p>	<p>Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100-400, 4200, Төрийн хяналт, шалгалтын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын журам, арга зүйг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа болон судалгаа авах, тайлан баримт материалд тулгуурлан харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэргээр аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.</p>
<p>Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт</p>	<p>Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Монгол Улсын үндсэн хууль • Төсвийн тогтвортой байдлын тухай хууль • Төсвийн тухай хууль • Төрийн аудитын тухай хууль • Монгол улсын 2019 оны төсвийн тухай хууль • Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль • Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль • Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль • Татварын багц хуулиуд • Шилэн дансны тухай хууль • Аймаг, сумын ИТХ-ын хуралдааны тогтоолууд, • Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт
<p>Аудитыг гүйцэтгэсэн хугацаа, аудитын</p>	<p>Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор Б.Мөнхбат удирдаж, аудитын менежер А.Цээням үе шатны ажлын чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Должмаа, аудитор Г.Ганчимэг, Н.Бүнчинсүрэн нар</p>

багийн
бүрэлдэхүүн

Аудитын
тайлангийн бүтэц,
түүнд тусгагдсан
мэдээлэл,
хэлэлцүүлсэн
журам

Аудит хийхэд
гарсан хүндрэл,
бэрхшээл

төлөвлөлтийн шатны ажлыг 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.

Аудитын тайланг үндсэн мэдээлэл, аудитын дүн, аудитын дүгнэлт, зөвлөмж гэсэн агуулгаар бичиж, аудитын тайланд аудитын менежер, тэргүүлэх аудитор нараар үе шатны хяналт хийлгэж, тайланг аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарт хүргүүлэв.

- Аймгийн СТХС, ЭМГ-ийн төсвийн мэргэжилтнүүдийн зардлын төлөвлөсөн дүнг аймгийн дүнгээр ахлах мэргэжилтэн нэгтгэж гаргадаггүй, салбар хариуцсан мэргэжилтнүүдийн гаргаж ирүүлсэн мэдээг тайлан, хянах тогтолцоо байхгүйгээс аудитын явцад аймгийн дүнг нэгтгэж гаргаж байгаа нь цаг хугацаа их шаарддаг.
- Орлогын мэргэжилтэн аймгийн Татварын хэлтсийн орлогын эдийн засагчтай аймгийн татварын орлогыг тулган баталгаажуулаагүй, орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр гаргаж ирүүлдэггүй, аудитад шаардлагатай судалгааг шаардсан хугацаанд үнэн зөв, бүрэн гаргаж ирүүлдэггүй
- “Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц”-д 2019 оны 09 дүгээр сард хийсэн аудитаар аймаг, сумдын ИТХ-ын тогтоолыг зөрүүтэй баталсан зөрчилд аудитаар зөвлөмж өгч тогтоолыг шинэчлэн гаргах зөвлөмжийг өгсөн ба сумын ИТХ-аар төсвийг залруулж батлахдаа шинээр тогтоол гаргаагүй, эхний тогтоолыг засч гаргасан нь аудит хийхэд хүндрэлтэй байлаа.

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС
АТӨЯХАТ
ЖДҮ
ЗДТГ
ИТХ
ОНӨ
ОНӨГ
ОНХС
СТСХ
СХС
ТБОНӨХ

ТБОНӨХБАУХАТХ

ТЕЗ
ТЗШ
УТХ
ҮАГ
ХХААГ
ХХК
ХХОАТ
ЦХТАО
ШШГГ
ЭМГ
ЭМТ

Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт
Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар
Жижиг дунд үйлдвэрлэл
Засаг даргын Тамгын газар
Иргэдийн төлөөлөгчдийн хурал
Орон нутгийн өмч
Орон нутгийн өмчийн газар
Орон нутгийн хөгжлийн сан
Санхүү төрийн сангийн хэлтэс
Сум хөгжүүлэх сан
Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгө
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
Төсвийн ерөнхийлөн захирагч
Тусгай зориулалтын шилжүүлэг
Улсын тэмдэгтийн хураамж
Үндэсний аудитын газар
Хүнс, хөдөө аж ахуйн газар
Хязгаарлагдмал хариуцлагатай компани
Хувь хүний орлогын албан татвар
Цалин хөлс түүнтэй адилтгах орлого
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
Эрүүл мэндийн газар
Эрүүл мэндийн төв

ХҮСНЭГТИЙН ТОВЬЁГ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	<i>ИТХ-аар баталсан төсвийг төсвийн төлөвлөлтийн программд зөрүүтэй оруулсан нэгтгэл</i>	7
Хүснэгт 2	<i>Татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл</i>	10
Хүснэгт 3	<i>Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл</i>	11
Хүснэгт 4	<i>Татварын орлогын төлөвлөгөөний биелэлт</i>	12
Хүснэгт 5	<i>Сумын хог хаягдлын хураамжийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл</i>	13
Хүснэгт 6	<i>Соёлын төвийн өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл</i>	14
Хүснэгт 7	<i>Зардлын ангилал /ТЭЗ-аар /</i>	16
Хүснэгт 8	<i>Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын төсөвт орсон өөрчлөлт</i>	16
Хүснэгт 9	<i>Төсөвт орсон өөрчлөлт</i>	17
Хүснэгт 10	<i>Аудитлагдсан төсвийн гүйцэтгэлийн тайлан</i>	18-21
Хүснэгт 11	<i>Зардлын гүйцэтгэл</i>	21
Хүснэгт 12	<i>Томилолт зочны зардал /</i>	24
Хүснэгт 13	<i>Сум хөгжүүлэх сангийн мэдээлэл</i>	25
Хүснэгт 14	<i>Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт</i>	28-29

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2018.11.29-ний өдрийн 14/03 тоот тогтоолоор аймгийн 2019 оны төсвийн зарлагыг 79839.1 сая төгрөгөөр баталснаас урсгал зардалд 72046.1 сая, хөрөнгийн зардалд 7793.0 сая төгрөгийг хуваарилсан байна.

Аймгийн ИТХ-ын 2019.04.19-ний өдрийн хуралдааны 16/02 тогтоолоор 2018 оны төсвийн үлдэгдлийн 715.1 сая төгрөгийг хуваарилж, тус хуралдааны “Аймгийн 2019 оны төсвийн хавсралтын зарим зардалд өөрчлөлт оруулах тухай” 16/03 тоот тогтоолоор аймгийн 2019 оны ОНХС-аас санхүүжих 100.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Цахилгаан халаагуураар Баянхонгор сумын иргэдийг хангах ажил”-ыг аймгийн ангилагдаагүй зардлаас санхүүжүүлэхээр өөрчлөлт оруулжээ.

Сумдын ИТХ-ын тогтоолоор 2019 оны орлогыг 7599.2 сая төгрөгөөр баталснаас татварын орлогыг 2396.3 сая, хүү торгуулийн орлогыг 242.5 сая, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 31.9 сая, хандив тусламжийн орлогоор 235.0 сая, ОНХС-ийн орлогоор 273.8 сая, СХС-ийн зээлийн эргэн төлөлтийн орлогоор 1890.1 сая төгрөг оруулж, урьд оны үлдэгдлээс 2529.6 сая төгрөгөөр санхүүжихээр баталжээ.

Тайлант онд аймгийн ИТХ-ын хуралдааны 2019.04.19-ний өдрийн 16/02 дугаар тогтоолоор урьд оны үлдэгдлээс 715.1, сумд 192.5 сая төгрөгийг тодотгож, аймгийн Засаг даргын 2019.09.24-ний өдрийн А/489 дугаар захирамжаар татварын буцаан олголтын хэмнэлтээс 240.0 сая төгрөгийг зохицуулалт хийж, нийт зардлыг 79839.1 сая төгрөгөөр баталжээ.

Аймгийн ТЕЗ-ийн дүнгээр 2019 оны 76537,3 сая төгрөгийг зарцуулснаас урсгал зардалд 69953.1 сая, хөрөнгийн зардалд 6584.2 сая төгрөг зарцуулсан байна.

Сумын ИТХ-ын хуралдаанаас сумын төсвийг батлахдаа эх үүсвэр, зардлыг зөрүүтэй баталдаг, сумын санхүүгийн албаны дарга, татварын улсын байцаагчтай татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг сар бүр тооцоо нийлж баталгаажуулахгүй байгаагаас татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын СТХС-ийн мэргэжилтнүүд сумдаас ирүүлсэн ИТХ-ын тогтоол, татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хянадаггүй, батлагдсан төсвийг Сангийн яамны төсвийн төлөвлөлтийн Fiscal программд зөрүүтэй оруулдаг, орлогын мэргэжилтэн төсвийн нэгтгэсэн орлогыг, ахлах мэргэжилтэн нь төсвийн зардлыг нэгтгэж гаргадаггүй зэргээс шалтгаалж, өмнөх онд илэрсэн алдаа зөрчил дахин давтагдсаар байна.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДҮН


БҮЛЭГ 1.

Аймгийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн татварын орлогын төлөвлөгөө аймгийн Татварын хэлтсийн мэдээнээс 9.1 сая, гүйцэтгэл нь 204.5 сая төгрөгөөр зөрүүтэй байна.

1.1 Аймгийн ИТХ-аар баталсан 132.3 сая, Жинст сумын ИТХ-аар баталсан 17.5 сая, Жаргалант сумын ИТХ-аар баталсан 1.0 сая төгрөгийн орлогыг Сангийн яамны төсвийн төлөвлөлтийн программд оруулаагүй орхигдуулсан байна.

1. Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулиар батлагдсанаар Баянхонгор аймгийн Засаг дарга Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний дагуу санхүүгийн дэмжлэгээр 15858.0 сая, тусгай зориулалтын шилжүүлгээр 40768.3 сая, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 6485.8 сая, Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох шилжүүлгийг 486.4 сая, урьд оны үлдэгдлээс 217.9 сая, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 99.5 сая төгрөгийг хуваарилсан бөгөөд аймгийн ИТХ-ын хуралдааны 2018.11.29-ний өдрийн 14/03 тоот тогтоолоор аймгийн татварын болон татварын бус орлогоор 7369.0 сая төгрөгийг оруулж, нийт 71284.9 сая төгрөгийг төвлөрүүлэн зарцуулахаар төсөв батлагдсан байна.

2. Тусгай зориулалтын шилжүүлгээр эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээнд 6330.1 сая, ерөнхий боловсролын үйлчилгээнд 23409.2 сая, сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд 10069.7 сая, газрын харилцаа кадастрын үйлчилгээнд 462.3 сая, хүүхэд хөгжил хамгааллын үйлчилгээнд 497.0 сая төгрөгийг зарцуулахаар баталсан байна.



3. Аймгийн ИТХ-ын 2019.04.19-ний өдрийн хуралдааны 16/02 тогтоолоор 2018 оны төсвийн үлдэгдлийн 715.2 сая төгрөгийг хуваарилж, тус хуралдааны “Аймгийн 2019 оны төсвийн хавсралтын зарим зардалд өөрчлөлт оруулах тухай” 16/03 тоот тогтоолоор аймгийн 2019 оны ОНХС-аас санхүүжих 100.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Цахилгаан халаагуураар Баянхонгор сумын иргэдийг хангах ажил”-ыг аймгийн ангилагдаагүй зардлаас санхүүжүүлэхээр өөрчлөлт оруулсан байна.

4. Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас 2019 оны нийт бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу өөрийн байгууллагын санаачилгаар “Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг шалгаж, нийт 2363.6 сая төгрөгийн алдаа илрүүлснээс 1961.2 сая төгрөгийн зөрчилд 8 албан шаардлага, 402.4 сая төгрөгийн 15 зөрчилд зөвлөмж хүргүүлж, биелэлтийг тооцож ажилласан.

Дээрх аудитаар аймаг, сумын ИТХ-ын хуралдааны тогтоолоор баталсан дүн 79321.1 сая төгрөг байхад Сангийн яамны төсвийн төлөвлөлтийн программд 79351.0 сая төгрөгөөр буюу 29.9 сая төгрөгөөр зөрүүтэй оруулсан алдаа зөрчил илэрсэнд өөрчлөлтийг 2019 оны 10 дугаар сард багтаан программд залруулах зөвлөмжийг өгсөн.

Хүснэгт 1. ИТХ-аар баталсан төсвийг төсвийн төлөвлөлтийн программд зөрүүтэй оруулсан нэгтгэл

НИЙТ ОРЛОГО	Аймаг	Сум	Нийт батлагдсан	Программд оруулсан	Зөрүү
Татварын орлого	6,212.00	2,396.25	8,608.25		(578.45)
Хүү, торгуулийн орлого	731.00	242.50	973.50		
Хандив тусламжийн орлого	350.00	235.00	585.00		
Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	76.00	-	76.00	26,679.23	
Аймгийн төсөвт Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	15,858.03	-	15,858.03		
Аймгийн төсөвт Улсын төсвөөс олгох ОНХС-ийн шилжүүлэг	6,485.88	-	6,485.88	6,485.87	0.00
Аймгийн төсөвт Улсын төсвөөс шилжүүлэх тусгай зориулалтын шилжүүлэг	40,768.31	-	40,768.31	40,778.31	(10.00)
Аймгийн төсөвт Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох шилжүүлэг	486.42	-	486.42	486.42	-
Төсөвт байгууллагын өөрийн орлого	99.50	2,185.29	2,284.79	2,431.09	(146.30)
Бусад орлого	-	10.47	10.47	-	10.47
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	847.43	2,337.07	3,184.50	2,490.17	694.3
ДҮН	71,914.5	7,406.5	79,321.1	79,351.1	29.9

Эх сурвалж: ИТХ-ын 2019 оны төсөв баталсан тогтоолууд, төлөвлөлтийн программаас хөрвүүлсэн файл

Мөн аудитаар сумдын ИТХ-ын тогтоолыг шалгахад сумдын дүнгээр 2019 оны төсвийн нийт эх үүсвэр 62931.1 сая төгрөг байхад зарим зардлыг бүрэн тусгаагүй, тооцооллыг алдаатай хийсэн зэргээс шалтгаалж төсвийн нийт зардлыг 62687.7 сая төгрөгөөр буюу 243.4 сая төгрөгөөр зөрүүтэй баталсан байна. Тухайлбал Баянбулаг сум 224.8 сая, Баянлиг сум 52.4 сая, Баян-Овоо сум 161.1 сая, Баянцагаан сум 0.6 сая, Гурванбулаг сум 1.0 сая, Шинэжинст сум 4.2 сая төгрөгөөр зардлыг дутуу, Галуут сум 2.5 сая, Жинст сум 107.1 сая, Заг сум 1.0 сая, Эрдэнэцогт сум 90.0 сая төгрөгөөр илүү баталсан байсныг залруулах албан шаардлагыг хүргүүлсэн.

Өгсөн албан шаардлагын дагуу сумын ИТХ-ын тогтоолыг зөрүүтэй баталсан сумд тогтоолыг шинээр гаргаагүй, төсөв баталсан анхны тогтоолыг засахдаа зөрүүтэй баталсан, нэр, төрлөөр нь зассан, орлогын төлөвлөгөөг төсвийн мэргэжилтэн төсвийн төлөвлөлтийн программд оруулаагүй орхигдуулсан зөрчлүүд бүрэн арилаагүй, давтагдаж байна.

Аудитын илрүүлэлт:

- Аймгийн ИТХ-ын хуралдааны 2018.11.29-ний өдрийн 14/03 тоот тогтоолын 2 дугаар хавсралтаар аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтын арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг батлахдаа техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулсны орлогоор 132.3 сая төгрөг баталсан байхад түүнийг төсвийн төлөвлөлтийн программд оруулаагүй;
- Засаг даргын 2019.10.28-ны өдрийн А/560 тоот захирамжаар Бөмбөгөр сумын ЭМТ-ийг төсөвт зохицуулалт хийж, нэмж 24.7 сая төгрөгийн төсвийн зохицуулалт

хийсэн байхад захирамжийн хавсралтыг 10.0 сая төгрөгөөр зөрүүтэй буюу 14.7 сая буюу төгрөгөөр гаргасан;

- Ихэнх сумд тогтоолын эх үүсвэр, зарлагын дүнг зөрүүтэй баталсан, Өлзийт, Баянбулаг сумд зардлын дүнг батлаагүй;
 - Жинст сумын тогтоолд сумын ОНХС-ийн оны эхний үлдэгдэл 14.2 сая төгрөгийг тогтоолд оруулж баталсан атлаа ОНХС-ийн зардлыг батлахдаа тус үлдэгдлийг хасч баталсан.
 - Аймгийн ИТХ-ын тогтоолоор ЭМДС-аас Баянбулаг суманд олгох 17.3 сая, Баян-Овоо суманд олгох 27.0 сая төгрөгийн олгох санхүүжилтийг сумын ИТХ-ын тогтоолд оруулаагүй орхигдуулж эх үүсвэр, зардлыг зөрүүтэй баталсан;
 - Аймгаас Өлзийт суманд тусгай зориулалтын шилжүүлгийг 1348.7 сая төгрөгийг баталсан байхад сумын ИТХ-ын тогтоолд 1187.2 сая төгрөгөөр тусгай зориулалтын шилжүүлгийг баталж, эх үүсвэр, зардлыг зөрүүтэй баталсан байна.
5. Аймгийн ИТХ-ын хуралдаанаар 2019 онд 1 удаа, аймгийн Засаг даргын захирамжаар 4 удаа төсөвт зохицуулалт хийжээ. Үүнд:
- ✓ Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1¹, 42.2.2²-т заасны дагуу аймгийн даргын төсөвт зохицуулалт хийх тухай 2019.04.25-ны өдрийн А/233 дугаар захирамжаар орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн 54 байгууллагууд төсөв хооронд;
 - ✓ Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18.1.2³ дахь заалтын дагуу аймгийн ИТХ-ын хуралдааны 2019.09.23-ны өдрийн 17/08 дугаар тогтоолоор 20 сумын төсөвт захирагч нарын ерөнхий боловсролын болон сургуулийн өмнөх боловсролын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсөв хооронд;
 - ✓ Аймгийн Засаг даргын 2019.09.24-ний өдрийн А/489 дүгээр захирамжаар татварын буцаан олголтын хэмнэлтийн 240.0 сая төгрөгийг аймгийн төвийн 7 байгууллагуудын төсөвт хооронд;
 - ✓ Аймгийн Засаг даргын 2019.10.28-ний өдрийн А/560 дугаар захирамжаар тусгай зориулалтын шилжүүлгийн 79 байгууллагын төсөв хооронд;
 - ✓ Аймгийн Засаг даргын 2019.12.16-ний өдрийн А/645 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралтаар орон нутгийн төсөвт 39 байгууллагын, хоёрдугаар хавсралтаар тусгай зориулалтын шилжүүлгийн 67 байгууллагын, гуравдугаар хавсралтаар эрүүл мэндийн салбарын 18 байгууллагын төсөвт зохицуулалт хийсэн байна.

6. Аймгийн төсвөөс сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг 13321.6 сая, ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 2821.3 сая, Засгийн газрын чиг үүргийг орог нутагт төлөөлөн хэрэгжүүлэх тусгай зориулалтын шилжүүлгийг 38895.3 сая, ЭМДС-аас олгох санхүүжилтийг 486.4 сая, нийт 63025.1 сая төгрөгөөр баталж, урьд

Сумдын 2019 оны нийт төсөв /сая.төг/

Урьд оны үлдэгдлээс	2770.1
СХС-ийн орлогоор	1783.4
ОНХС-ийн орлогоор	124.9
ОНТБӨО	38.2
Хандив тусламжийн орлого	217.8
Хүү торгууль	231.8
Татварын орлого	2420.8
Аймгийн төсвөөс авах дэмжлэг	55486.3

¹ "Төсвийн захирагч төсөвтөө дараах байдлаар зохицуулалт хийж болно" 42.2.1. төсвийн ерөнхийлөн захирагч нь:

² "Төсвийн захирагч төсөвтөө дараах байдлаар зохицуулалт хийж болно: төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд хамаарах төсвийн шууд захирагчдын төсөв хооронд"

³ Засаг даргын өргөн мэдүүлснээр сум, дүүргийн төсвийг хэлэлцэж батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлах;

оны үлдэгдлээс 3462.5 сая, аймгийн төсөвт байгууллагуудад нийт 16814.0 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталсан байна.

7. Сумдын ИТХ-аар баталсан сумдын нийт төсөв 63085.3 сая төгрөг баталснаас төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө 38.2 сая төгрөг байгаа нь тайлант онд соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагааны орлогыг батлахгүй байхаар шийдвэрлэсэнтэй холбоотой байна.

8. Аймгийн 2019 оны орон нутгийн орлого өмнөх оноос 898.9 сая төгрөгөөр буурч, 12778.1 сая төгрөгөөр төлөвлөсөн нь татварын орлого, сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлого нэмэгдсэн, хандив тусламжийн орлого өмнөх оноос буурсантай холбоотой байна.

9. Аймгийн ТЭЗ-ийн татварын орлогыг өмнөх оноос 914.7 сая, Сангийн яамны хянасан дүнгээс 1260.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 2019 онд 8870.8 сая төгрөг оруулахаар төлөвлөснөөс аймгийн нэгдсэн төсөвт төвлөрөх орлогыг 6199.0 сая, сумдын татварын орлогыг 3231.8 сая төгрөгөөр оруулахаар төлөвлөж, хувь хүний орлогын албан татварын буцаан олголтод 560.0 сая төгрөгийг олгохоор баталжээ.

Хүснэгт 2. Татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

Орлогын төрөл	2017 оны гүйцэтгэл	2018 онд Сангийн яамны хянасан	2018 оны төлөвлөгөө	2018 оны гүйцэтгэл	2019 онд Сангийн яамны хянасан	2019 оны төлөвлөгөө	Өөрчлөлт	
							Өмнөх оны төлөвлөгөөнөөс	Сангийн яамны хянаснаас
Татварын орлогын дүн	8,940.5	6,511.5	7,956.1	8,543.8	7,610.0	8,870.8	914.7	1,260.8
1.Аймгийн нэгдсэн төсөв төсөв	5,302.6	4,670.0	5,007.4	5,268.8	5,281.9	5,639.0	631.8	357.1
а. ЦХТАО /суутган-1/	5268.70	4800.00	5050.00	5101.70	5252.8	5,253.0	203.0	0.2
б. Хувь хүний орлогын буцаан олголт	-771.40	-800.00	-800.00	-656.60	-800.0	-560.0	240.0	240.0
в. АТӨЯХАТ	399.70	370.00	433.00	441.40	420.0	426.0	-7.0	6.0
г.Газрын төлбөр	158.00	120.00	124.00	118.60	160.0	270.0	146.0	110.0
д. Үл хөдлөх хөрөнгийн татвар	247.60	180.00	200.40	283.70	249.1	250.0	49.6	0.9
2. Орон нутгийн төсөв	3,637.9	1,841.5	2,948.7	3,255.0	2,328.1	3,231.8	283.1	903.7
Хүн амын орлого	2038.7	1160.5	1227.0	1601.0	1306.5	1481.0	254.0	174.5
а. Үйл ажиллагааны орлого /ИОТХ/	632.3	400	451.5	482.1	308.0	381.0	-70.5	73.0
б. Үл хөдлөх хөрөнгө борлуулсны татвар	405.5	65	80	0.7	96.1	100.0	20.0	3.9
в. Хөрөнгийн орлого /Хадгаламжийн хүү/	948.2	650	650	1063	855.9	950.5	300.5	94.6
г. Бууны татвар	52.7	45.5	45.5	55.2	46.5	49.5	4.0	3.0
Бусад төлбөр хураамж	1,599.20	681.00	1,721.70	1,654.00	1,021.60	1,750.80	29.10	729.20
а.Улсын тэмдэгтийн хураамж	231.7	215	237	247.9	270.0	273.2	36.2	3.2
б. Газрын дуудлага худалдааны орлого	0	0	200	321.6	0.0	150.0	-50.0	150.0
в. Орон нутгийн зам ашигласны төлбөр	0	0	147.8	0	0.0	194.6	46.8	194.6
г. Хог хаягдлын үйлчилгээний хураамж	301.9	0	308.5	314.8	300.0	506.3	197.8	206.3
д.ус рашаан ашигласны төлбөр	438.8	250	400	264.6	200.0	253.3	-146.7	53.3
е..Түгээмэл тархацтай АМАТөлбөр	8.4	9	12	12	12.0	25.7	13.7	13.7
ё.Ан, амьтан агнуурын нөөц ашигласны	602.9	200	407.9	468.5	239.6	339.5	-68.4	99.9
ж.Нохойны татвар	8.9	7	8.5	8.9	0	8.2	-0.3	8.2
з.Бусад татвар	6.6	0	0	15.7	0	0	0.0	0.0

Эх сурвалж: Өмнөх оны аудитын тайлан, 2019 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудитын илрүүлэлт:

• Сумын ИТХ-аар баталсан татварын орлогыг аймгийн Татварын хэлтсээс ирүүлсэн татварын мэдээний төлөвлөгөөтэй тулгахад Заг сум 1.0 сая, Жинст сум 1.0 сая төгрөгийн татварын орлогыг татварын мэдээнд оруулаагүй байна.

10. Аймгийн ИТХ-ын хуралдааны 2018 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 14/03 тоот тогтоолоор хүү торгуулийн орлогыг 731.0 сая, сумдын ИТХ-ын хуралдааны

тогтоолоор 231.7 сая, нийт 962.7 сая төгрөгөөр оруулахаар төлөвлөсөн нь өмнөх оноос 141.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Өмнөх онд тооцоо судалгаанд үндэслэлгүй төлөвлөсөн хандив тусламжийн орлогыг бууруулж, тайланд онд аймагт 350.0 сая, 4 сумын дүнгээр 242.1 сая төгрөгийн орлого оруулахаар баталсан бөгөөд Жинст сумын хандив тусламжийн орлогын 12.1 сая төгрөгийг төсвийн төлөвлөлтийн программд оруулаагүй, орлогын мэргэжилтэн орлогын мэдээнд нэгтгээгүй орхигдуулсан байна.

11. Аймгийн ИТХ-ын хуралдааны 2018 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 14/06 тоот тогтоолоор орон нутгийн өмчид бүртгэлтэй 8 үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах шийдвэр гарсан байхад дээрх хөрөнгүүдийн худалдах доод үнийг тогтоогоогүй, хэдэн төгрөгөөр борлуулах урьдчилсан судалгаа хийлгүйгээр төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсан орлогыг 2019 онд 76.0 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

12. Сангийн яамнаас орон нутгийн 2019 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл, удирдамжид “Соёл урлагийн байгууллагуудын үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг батлаагүй ба уран бүтээл туурвиж орсон орлогыг ажилтнуудын нийгмийн баталгааг хангахад шаардлагатай зардалд бие даан зарцуулах эрхтэй байна” гэж заасны дагуу Баацагаан, Баян-Овоо, Баянговь, Хүрээмарал, Жаргалант, Өлзийт сумдын соёлын төвөөс бусад соёлын байгууллагууд өөрийн орлогыг төлөвлөөгүй байна.

13. Аймгийн ТЕЗ-ийн харьяаны байгууллагуудын өөрийн орлогоор 2019 онд 99.5 сая, сумдын орон нутгийн байгууллагын өөрийн орлогоор 26.2 сая, соёлын төвүүдийн орлогоор 12.0 сая, сумдын СХС-ийн зээлийн эргэн төлөлтийн орлогоор 1783.4 сая, ОНХС-ийн орлогоор 124.8 сая төгрөгийг баталсан байна.

1.2. Санхүүгийн тайлангийн татварын орлогын төлөвлөгөөг аймгийн Татварын хэлтсийн татварын орлогын мэдээнээс 9.1 сая төгрөгөөр дутуу, гүйцэтгэлийг 204.5 сая төгрөгөөр илүү, нэр төрлөөр нь зөрүүтэй тайлагнасан байна.

14. Аймгийн дүнгээр 2019 онд орон нутгийн орлогоор 12778.1 сая төгрөгийн орлого оруулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 13962.0 сая төгрөгийг оруулж, төлөвлөгөөг 1183.9 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 3. Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Орлогын нэр төрөл	Төлөвлөгөө	Үүнээс		Гүйцэтгэл	Зөрүү
		Аймаг	Сум		
Татварын орлого	8870.8	5639.0	3231.8	10888.5	-2017.7
Хүү, торгуулийн орлого	973.5	731.0	242.5	1171.4	-197.9
Төсөвт байгууллагуудын өөрийн орлого	2272.8	99.5	2173.3	1695.9	576.9
Хандив тусламжийн орлого	585.0	350.0	235.0	135.0	450.0
ЖДҮ-ийн зээлийн эргэн төлөлт	0.0	0.0	0.0	0.0	0.0
ОНӨ-ийн хөрөнгө борлуулсны орлого	76.0	76.0	0.0	71.2	4.8
Дүн	12778.1	6895.5	5882.6	13962.0	-1183.9

Эх сурвалж: Аймаг, сумын ИТХ-ын тогтоол, төсвийн гүйцэтгэлийн тайлан

15. Үүнээс татварын орлогоор 2019 онд 8870.8 сая төгрөг оруулахаас хог хаягдлын хураамжийн орлогоос бусад татварыг нэр төрөл тус бүрээр давуулан биелүүлж, 10888.5 сая төгрөгийг оруулж, төлөвлөгөөг 2017.7 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн сайн үзүүлэлттэй байна. Гэвч Татварын хэлтсээс ирүүлсэн татварын мэдээг тайлангийн дүнтэй тулгахад төлөвлөгөө 9.1 сая, гүйцэтгэл 204.5 сая төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь татварын орлогын гүйцэтгэлийг нэр төрлөөр нь тайлагнаагүй, төсөвт байгууллагууд үндсэн үйл ажиллагааны орлогыг байгууллагын үндсэн дансанд орсныг татварын байцаагч төсөвт байгууллагын өөрийн орлогоор мэдээлсэн ба тус мэдээлэгдсэн орлогыг оны эцэст нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 4. Татварын орлогын төлөвлөгөөний биелэлт /сая төгрөг/

Д/Д	Орлогын төрөл	Төлөвлөгөө			Гүйцэтгэл		
		Нэгдсэн тайлангаар	Татварын мэдээгээр	Зөрүү	Нэгдсэн тайлангаар	Татварын мэдээгээр	Зөрүү
	Нийт орон нутгийн төсөв	9,821.2	9,830.3	9.1	12,059.9	11,855.4	-204.5
	Татварын орлого	8,869.7	8,870.8	1.1	10,888.5	10,684.0	-204.5
1	1.Аймгийн төсөв	5,639.0	5,639.0	0.0	6,840.5	6,034.4	-806.1
	1. ЦХТАО /суутган-1/	5,253.0	5,253.0	0.0	5467.2	5467.2	0.0
	Буцаан олголт	-560.0	-560	0.0	-548.0	-548.0	0.0
	2. АТӨЯХАТ	426.0	426	0.0	507.6	507.6	0.0
	3. Үл хөдлөх хөрөнгийн татвар	250.0	250	0.0	282.8	276.6	-6.2
	4.Газрын төлбөр	270.0	270	0.0	1130.9	331.0	-799.9
2	2. Орон нутгийн төсөв	4,182.2	4,191.3	9.1	5,219.4	5,821.0	601.6
1	Хүн амын орлого	1331.0	1331.5	0.5	1924.0	1694.1	-229.9
	1.1.ИОТТХ	381.0	381.0	0.0	779.5	549.4	-230.1
	1.2 Хадгаламжийн хүүгийн орлого	950.0	950.5	0.5	1144.5	1144.7	0.2
2	2. Үл хөдлөх хөрөнгө борлуулсны	100.0	100	0.0	220.4	142.5	-77.9
3	3. Бууны татвар	49.5	49.5	0.0	50.4	50.4	0.0
4	5. Бусад төлбөр хураамж	1,750.2	1,750.8	0.6	1,853.2	2,762.6	909.4
	а.Улсын тэмдэгтийн хураамж	273.2	273.2	0.0	305.1	304.1	-1.0
	б. Газрын дуудлага худалдаа	150.0	150	0.0	54.1	854.0	799.9
	в. Хог хаягдлын хураамж	506.3	506.3	0.0	481.8	487.0	5.2
	г.Ус рашаан ашигласны төлбөр	253.3	253.3	0.0	334.1	334.1	0.0
	д.Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	25.7	25.7	0.0	25.4	29.3	3.9
	е.Ан, амьтан агнуурын нөөц ашигласны	339.5	339.5	0.0	515.6	524.8	9.2
	ж.Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	0.0	0.0	0.0	0.1		-0.1
	ё.Нохойны татвар	8.2	8.2	0.0	8.8	9.2	0.4
	ж.Бусад татвар	0.0		0.0	111.9		-111.9
	Зам ашигласны хураамж	194.0	194.6	0.6	16.3	220.1	203.8
6	Татварын бус орлого	951.5	959.5	8.0	1171.4	1171.4	0.0
	Хүү торгууль	951.5	959.5	8.0	1171.4	1171.4	0.0
7	ТБӨО	121.0	124.7	3.7	127.3	118.7	-8.6

Эх сурвалж: аймгийн Татварын мэдээ, ТЕЗ-ын төсвийн гүйцэтгэлийн тайлан

16. Аймгийн СТСХ-ийн орлогын мэргэжилтэн, аймгийн Татварын хэлтсийн орлогын эдийн засагч нарын ажлын уялдааг сайжруулах зөвлөмжийг өмнөх аудитаар өгсөн байхад татварын орлогын гүйцэтгэлийг аймгийн ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэлийн тайланд зөрүүтэй илэрхийлсэн алдаа дахин давтагдаж байгаа тул цаашид анхаарч ажиллах шаардлагатай байна.

Аудитын илрүүлэлт:

- Галуут сумын татварын байцаагч ОНХС-ийн орлогын 12.0 сая төгрөгийг ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогоор мэдээлснээс татварын орлого энэ дүнгээр илүү мэдээлэгдсэн байна.

17. Харин хог хаягдлын хураамжийн орлогоор 506.3 сая төгрөг оруулахаар баталснаас гүйцэтгэлээр 487.0 сая төгрөг оруулж, төлөвлөгөө 19.3 сая төгрөгөөр тасарсан байна.

Хүснэгт 5. Сумын хог хаягдлын хураамжийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл / сая төгрөг/

Сумын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Сумын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Баацагаан	3.5	2.6	-0.9	Бууцагаан	3.2	3.3	0.1
Баянбулаг	9.0	9.8	0.8	Галуут	3.0	3.5	0.5
Баянговь	11.5	9.2	-2.3	Гурванбулаг	2.5	0.6	-1.9
Баянлиг	4.0	1.2	-2.8	Жаргалант	2.5	0.7	-1.8
Баян-Овоо	4.8	5.2	0.4	Жинст	2.5	2.7	0.2
Баян-Өндөр	2.5	0.9	-1.6	Заг	2.5	2.3	-0.2
Баянхонгор сум	430.3	424.4	-5.9	Өлзийт	4.0	4.2	0.2
Баянцагаан	6.0	3.9	-2.1	Хүрээмарал	2.5	0.0	-2.5
Богд	2.5	3.1	0.6	Шинэжинст	3.0	3.7	0.7
Бөмбөгөр	3.0	5.4	2.4	Эрдэнэцогт	3.5	0.2	-3.3
		ДҮН			506.3	487.0	-19.3

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн мэдээ, СТСХ-ийн мэдээ

Хүрээмарал сум хог тээврийн машингүй, нэгдсэн журмаар хог тээвэрлэх үйлчилгээ үзүүлдэггүйгээс орлого ороогүй, Эрдэнэцогт сум хог хаягдлын хураамжийн орлогын төлөвлөгөөг 6.8%, Гурванбулаг сум 23.8%, Жаргалант сум 28.3%, Баянлиг сум 31.1%, Баян-Өндөр сум 37.0% биелүүлсэн байхад “Баянхонгор Эрчим хүч” ЦТХХК-тай гэрээ байгуулж, хогны орлогыг цахилгааны төлбөр дээр нэмж авч байгаа сумдын орлогыг судалж үзэхэд Бөмбөгөр сум 181.2%, Баянбулаг сум 109.1%, Бууцагаан сум 102.2%-аар орлогын төлөвлөгөөг биелүүлснээс харахад цаашид хогны орлогыг эрчим хүчний төлбөртэй хамт авах нь орон нутгийн орлогын бүрдүүлэлтэд эергээр нөлөөлөх тул аймгийн Засаг даргад энэ талаарх зөвлөмжийг хүргүүлэв.

18. ХХОАТ-ын буцаан олголтод 2019 онд 800.0 сая төгрөг олгохоор батлагдсан боловч аймгийн Татварын хэлтсийн даргын 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/22 тоот тушаалаар 1246 татвар төлөгчид 538.6 сая төгрөгийн албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэхээр баталж, гүйцэтгэлээр 547.9 сая төгрөг олгож, батлагдсан зардлаас 9.3 сая төгрөгийг илүү олгосон нь өмнөх онд олгогдоогүй татварын буцаан олголтыг олгосонтой холбоотой байна.

19. Хандив тусламжийн орлогыг 585.0 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 2 аж ахуйн нэгжээс 135.0 сая төгрөг хандивлаж, орлого 450.0 сая төгрөгөөр тасарсан байна.

20. ТБОНӨХ-д бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлогоор 76.0 сая төгрөг төлөвлөснөөс 5 суудлын автомашин, 8 үл хөдлөх хөрөнгө борлуулж, дуудлага худалдааны орлогоор 71.0 сая, өмнөх оны дутуу 2.6 сая төгрөгийн орлогыг оруулж, төлөвлөгөө 5.0 сая төгрөгөөр тасарч, орлогын биелэлт 93.4 хувьтай байна.

21. Сумдын 6 соёлын үйл ажиллагааны орлогоор 12.0 сая төгрөг оруулахаар төлөвлөснөөс 7.4 сая төгрөгийн орлого оруулсан байна.

Хүснэгт 6. Соёлын төвийн өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

Сумын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Сумын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Баацагаан	3.5	0.9	-2.6	Жаргалант	1.5	1.4	-0.1
Баянговь	3.5	1.8	-1.7	Заг		1.3	1.3
Баян-Овоо	1	0.4	-0.6	Өлзийт	0.5	0.5	0
Галуут	0	0.8	0.8	Хүрээмарал	2	0.3	-1.7
НИЙТ					12.0	7.4	-4.6

Эх сурвалж: Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

21. Сумдын Соёлын төвүүд ихэвчлэн 5 орон тоогоор ажиллаж байгаа ба аймгийн орон нутгийн хөрөнгөөс сүүлийн 2 жилд суудлын автомашин авч өгсөн, 2019 онд нийт Соёлын төвийн дүнгээр төсвөөс 1717.6 сая төгрөгийн санхүүжилт авсан байхад өөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллаагүй ба 11 сумын Соёлын төв нэг ч төгрөгийн орлого оруулаагүй байна.

22. Сангийн сайдын 2019 оны 74 тоот тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын 3.4.3⁴-т заасны дагуу аймгийн ХДТ, Тэмүжин театр, сумдын Соёлын төв, Спорт хороо зэрэг соёл урлагийн байгууллагуудын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болж байгаа орлогыг төсвийн бүрэлдэхүүн хэсэгт оруулж төлөвлөх нь зүйтэй гэж “Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц”-д 2019 оны эхний 6 сарын байдлаар хийсэн гүйцэтгэлийн аудитаар дүгнэж, 2020 оны аймгийн төсвийн төсөлд дээрх үндэслэлээр сумын соёлын төвийг 1.5 сая төгрөг оруулахаар тооцож, саналыг оруулсныг хүлээн авч өөрийн орлогыг төлөвлөсөн байна. Өмнөх жилүүдэд хийж гүйцэтгэсэн аудитын дүнгээс харахад цөөн хэдэн сумын Соёлын төв өөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлж, ихэнх соёлын төв орлогыг биелүүлдэггүй, хуваарилагдсан төсвийн зардлаа бүрэн зарцуулдаг тул орлогын биелэлтэд орлогын мэргэжилтэн хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллах нь зүйтэй байна.

Аудитын илрүүлэлт

- Төсөвт байгууллагууд өөрийн орлогын төлөвлөгөө өгөөгүйгээс үйл ажиллагааны орлогыг байгууллагын дансанд төвлөрүүлдэггүй, бэлнээр зарцуулдаг, бий болсон орлогыг үйл ажиллагааны орлогоор тайлагналгүй нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, оны эцэст зарцуулсан нийтлэг зөрчилтэй асуудал санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн байна.

⁴ “үндсэн үйл ажиллагааны буюу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх явцад бий болдог жил бүр давтагдах шинжтэй тогтмол орлогыг төсөвт тусгахгүй орхигдуулахыг хориглоно”

БҮЛЭГ 2.

Зардлыг оновчтой төлөвлөөгүйгээс төсвийн жилийн дундуур төсөвт зохицуулалт хийдэг, оны эцэст хэмнэгдсэн зардлыг зохицуулалт хийлгэж зориулалт бусаар зарцуулсан байна.

2.1. Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн төсвийн мэргэжилтнүүд аймгийн ТЕЗ-ийн 2019 оны төсвийн зарлагыг үндэслэлтэй төлөвлөөгүй байна.

23. Аймаг, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоолоор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны зардлыг анх 78691.5 сая төгрөгөөр баталж, аймгийн ИТХ-ын хуралдааны 2019 оны 04 сарын 19-ны өдрийн 16/02 тоот тогтоолоор өмнөх оны үлдэгдлээс 715.1 сая, аймгийн Засаг даргын 2019.09.24-ний өдрийн А/489 дүгээр захирамжаар татварын буцаан олголтын хэмнэлтийн 240.0 сая төгрөгийг төгрөгийг нэмж, сумд оны эхний үлдэгдлээс 78.5 сая төгрөгийг тодотгож, нийт төсвийг 79839.1 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ТЕЗ-ийн 2019 оны урсгал зардлыг өмнөх оноос 5997.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж 72046.1 сая, хөрөнгийн зардлыг 76.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж 7793.0 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.



Өмнөх оноос урсгал зардал 7029.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Засгийн газрын тогтоолоор цалин нэмэгдсэн, Эрдэнэцогт, Өлзийт сумын ЗДТГ, цэцэрлэг, Баян-Ойт цогцолбор сургуулийн барилга шинээр ашиглалтад орсон, Хүрээмарал, Гурванбулаг сумд төвлөрсөн халаалтад холбогдсон, Баянхонгор сумын 5 дугаар сургууль, 16 дугаар цэцэрлэгийг 2019 онд ашиглалтад оруулахаар тооцож хүүхдийн тоог өмнөх оноос 738-аар нэмэгдүүлсэн, 14 дүгээр цэцэрлэг нь 3 дугаар багт эмзэг бүлгийг хамруулсан 1 бүлэг нэмж ажиллуулсан, Эрдэнэцогт сумын Сэмжитийн багт 1 бүлэг, Баянговь сумын шинээр цэцэрлэг баригдсанаас 1 бүлэг нэмэгдсэн, зарим төсөвт байгууллагуудын барилга шинээр баригдсантай холбоотой эд хогшил худалдан авах зардлыг нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.

24. Аймгийн ТЕЗ-ийн дүнгээр нийт 79839.1 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн бөгөөд төсөл хөтөлбөр, арга хэмжээ тус бүрээр ангилан авч үзвэл нийт зардлын 53.3 хувийг БСШУС-ын багцын байгууллагын зардал эзэлж байна.

Хүснэгт 7. Зардлын ангилал /ТЕЗ-аар / /сая төгрөг/

Үзүүлэлт	Нийт дүн	Үүнээс:				
		БСШУС-ын сайд	ХАХНХ-ын сайд	ЭМС-ын сайд	БХБ-ын сайд	Орон нутгийн засаг захиргаа
Батлагдсан төсөв	79,839.2	42,624.5	510.0	7,363.1	493.6	28,848.0
Зардлын гүйцэтгэл	75,920.4	42,372.5	509.3	7,188.4	493.2	25357.0
Хэтрэлт хэмнэлт	3,918.7	251.9	0.7	174.6	0.5	3,491.0

Эх сурвалж: Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

25. Сумын ИТХ-аар баталсан орлогыг орлогын болон төсвийн мэргэжилтнүүд хянадаггүйгээс Сангийн яамны төсвийн төлөвлөлтийн программд зардлын төлөвлөлт дутуу илэрхийлэгдсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Жаргалант сумын ИТХ-ын 2018.12.17 өдрийн 13/08 тогтоолоор сумын Ерөнхий боловсролын сургуулийн өөрийн орлогыг 1.0 сая төгрөгөөр баталсан байхад төсвийн төлөвлөлтийн программд оруулаагүй;
- Жинст сумын ИТХ-ын 2018.12.18-ний өдрийн 8/14 дүгээр тогтоолоор 17.3 сая төгрөгийг тодотгосон байхад төсвийн төлөвлөлтийн программд оруулаагүй;
- Жинст сумын ИТХ-аар хандив тусламжийн орлогыг 12.2 сая төгрөгөөр баталсан байхад төсвийн төлөвлөлтийн программд оруулаагүй байна.

26. Баянхонгор аймгийн Засаг дарга Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний дагуу тусгай зориулалтын шилжүүлгээр 40768.3 сая төгрөгөөр баталж, төсвийн төлөвлөлтийг зөв оновчтой хийгээгүйгээс аймгийн ИТХ-ын хуралдаанаар 1, аймгийн Засаг даргын захирамжаар 3 удаа төсөвт зохицуулалт хийхдээ шийдвэрийг зохицуулалт хийсний дараа нөхөн гаргасан байна.

Хүснэгт 8. Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын төсөвт орсон өөрчлөлт

Байгууллага	Тоо	Анх батлагдсан төсөв	Тодотгосон төсөв	Зөрүү
Ерөнхий боловсролын сургууль	29	23345.9	23069.8	-276.1
Сургуулийн өмнөх боловсрол	36	9681.3	9898.1	216.8
Эрүүл мэндийн төв	17	5868.1	5853.2	-14.9
Сумын дүн	82	38895.3	38821.1	-74.2
Өрхийн эмт	5	462.0	476.9	14.9
Хувийн цэцэрлэг	7	388.4	388.4	0.0
Хувийн сургууль	2	43.3	102.6	59.3
ГБХЗХГ	1	496.9	496.9	0.0
ГХБХБГ	1	462.4	462.4	0.0
Насан туршийн боловсрол	1	20.0	20.0	0.0
Аймгийн төвийн дүн	17	1873.0	1947.3	74.2
Нийт	99	40768.3	40768.3	0.0

Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын тогтоол, аймгийн Засаг даргын захирамж

27. Төсөвт байгууллагуудад хийсэн анхны, тодотгосон төсөвтэй харьцуулахад аймгийн ИТХ-ын хуралдаанаар анх Баянхонгор сумын 5 дугаар сургуульд хуваарилсан төсвийг бусад тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад хуваарилсан байна.

Хүснэгт 9. Төсөвт орсон өөрчлөлт /сая төгрөг/

Зарлагын төрөл	Батлагдсан төсөв	Тодотгосон төсөв	Өөрчлөлт
Аймгийн 2019 оны төсвийн жилд зарцуулах зарлагын дүн	78,691.50	79,839.20	1,147.60
Аймгийн ИТХ	583.9	583.9	-
Аймгийн Засаг даргын харьяаны байгууллага	78,107.60	79,255.20	1,147.60
Сумдын ИТХ	1,427.80	1,439.60	11.9
Сумдын ЗДТГ	7,559.90	7,674.50	114.6
Сумдын Орон нутгийн хөгжлийн сан	3,645.70	4,105.70	460
Сумдын сум хөгжүүлэх сан	2,988.80	2,969.60	-19.2
Сумдын ерөнхий боловсролын сургууль	25,647.90	26,213.20	565.3
Сумдын цэцэрлэг	10,803.40	11,938.60	1,135.20

БАЯНХОНГОР АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2019 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Сумдын эрүүл мэндийн төв	6,919.70	6,892.10	-27.5
Сумдын соёлын төв	1,716.40	1,717.60	1.2
Баянхонгор аймаг	17,398.10	16,304.40	-1,093.70
Аймгийн Засаг даргын тамгын газар	2,058.30	2,222.30	164
Асрамжийн газар	119.8	119.8	0
Засаг дарга /ангилагдаагүй зардал/	2,822.40	3,052.10	229.7
Байгаль орчин, аялал жуулчлалын газар	730.9	721.9	-9
Замын сан	706.1	904.7	198.6
Ойн анги	73.8	75.8	2
Халамжийн сан	196.5	246.1	49.7
Түүх угсаатны зүй, байгалийн музей	210.9	210.9	-
Нийтийн номын сан	145.8	156.8	11
Биеийн тамир спортын газар	635.6	635.6	-
Хүүхдийн Тэмүжин театр/	352.8	366.2	13.4
Хөгжимт драмын театр	869.5	868.5	-1
Хүүхэд, гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар	512	510	-2
Санхүүгийн хяналт, аудитын алба	143.6	145	1.4
Орон нутгийн өмчийн газар	167.5	180.5	13
Хот тохижилт, үйлчилгээний газар	627.2	637.2	10
Баянхонгор аймаг Гадаад харилцаа, аялал жуулчлалын алба	80	82	2
Хувийн сургууль /5 дугаар сургууль орсон/	1,660.60	102.6	-1,558.00
Хувийн цэцэрлэгүүд	641.7	388.4	-253.3
Өрхийн эмнэлэг	462	476.9	14.9
Аймгийн ОНХС	3,687.30	3,687.30	-
Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	493.6	493.6	-
Насан туршийн боловсрол	-	20	20

Эх сурвалж: Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явцад хийсэн аудитаар аймгийн СТСХ-ээс авсан төсвийн төлөвлөлтийн программаас хөрвүүлсэн файл, аудитын явцад хийсэн 2019 оны тогтоолыг нэгтгэсэн нэгтгэл

2.2. Зардлын ангиллыг зориулалтын дагуу үнэн зөв тайлагнаагүй байна.

28. Аймгийн ТЕЗ-ийн гүйцэтгэлээр улсын төсвөөс санхүүгийн дэмжлэгээр 15858.0 сая, тусгай зориулалтын шилжүүлгээр 40768.3 сая, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 6292.4 сая, Эрүүл мэндийн даатгалын сангаас 468.1 сая төгрөгийг авч, орон нутгийн татварын орлогоор 10888.6 сая, үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлогоор 16413.6 сая төгрөгийн орлого оруулж, урьд оны үлдэгдлээс 703.3 сая төгрөг авч, төсөвт байгууллагуудын зардлын зарцуулаагүй үлдсэн харилцах дансны үлдэгдэл, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын 305.9 сая төгрөгийг буцаан төвлөрүүлж, нийт 76537.3 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулж, төсөвт зардлыг 3301.8 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

БАЯНХОНГОР АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2019 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Хүснэгт 10. Аудитлагдсан төсвийн гүйцэтгэлийн тайлан / сая төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	73,918.49	69,508.17	79,839.16	76,537.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	66,048.73	64,381.72	72,046.11	69,953.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	52,372.43	51,117.45	68,920.07	66,868.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	29,767.20	29,696.93	37,635.00	37,501.49
210101	Үндсэн цалин	24,536.93	24,509.17	29,975.37	30,039.42
210102	Нэмэгдэл	3,061.52	3,087.39	4,141.06	4,127.27
210103	Унаа хоолны хөнгөлөлт	107.03	103.88	212.00	195.15
210104	Урамшуулал	1,457.98	1,417.73	2,603.90	2,486.63
210105	Гэрээт ажлын хөлс	603.74	578.77	702.67	653.02
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,614.58	3,578.02	4,820.24	4,767.93
210201	Тэтгэврийн даатгал	2,466.82	2,609.46	3,384.16	3,378.99
210202	Тэтгэмжийн даатгал	282.18	243.52	358.77	350.89
210203	ҮОМЦӨ-ний даатгал	228.53	196.77	287.42	275.36
210204	Ажилгүйдлийн даатгал	57.31	49.73	71.72	68.44
210205	Эрүүл мэндийн даатгал	579.74	478.54	718.16	694.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,738.04	6,714.59	7,766.26	7,660.59
210301	Гэрэл, цахилгаан	469.12	463.74	529.99	545.01
210302	Түлш, халаалт	5,768.88	5,749.27	6,711.44	6,612.38
210303	Цэвэр, бохир ус	432.61	416.99	442.10	423.73
210304	Байрны түрээс	67.43	84.59	82.73	79.46
2104	Хангамж, бараа материалын зардал	1,388.16	1,377.27	1,937.50	1,880.66
210401	Бичиг хэрэг	187.22	190.51	234.83	255.08
210402	Тээвэр, шатахуун	850.21	846.60	1,034.56	987.22
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	151.60	142.00	231.73	196.56
210404	Ном, хэвлэл	28.96	26.36	118.92	108.21
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	25.41	25.45	57.42	54.66
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	144.75	146.34	260.05	278.94
2105	Норматив зардал	2,899.61	2,886.53	3,219.67	3,145.18
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	311.59	310.07	482.11	447.64
210502	Хоол, хүнс	2,426.44	2,413.88	2,498.53	2,469.31
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	161.57	162.58	239.03	228.23
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	668.22	652.93	2,679.73	2,641.93
210601	Багаж, техник, хэрэгсэл	151.29	151.89	343.34	350.31
210602	Тавилга	95.24	83.82	860.07	827.71
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2.50	2.50	15.56	17.11
210604	Урсгал засвар	419.18	414.72	1,460.75	1,446.80
2107	Томиллолт, зочны зардал	346.21	338.07	591.14	574.92
210701	Гадаад албан томиллолт	60.00	58.43	78.91	77.73

БАЯНХОНГОР АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2019 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

210702	Дотоод албан томилолт	263.34	256.93	388.76	359.71
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	22.87	22.72	123.47	137.48
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,206.21	1,932.60	5,290.15	3,881.67
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,132.50	1,861.66	5,189.22	3,782.78
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2.89	2.71	26.65	26.58
210803	Даатгалын үйлчилгээ	14.29	13.59	13.16	12.93
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3.84	3.55	6.17	5.80
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	1.55	1.29	2.54	2.24
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	46.56	45.78	48.17	47.40
210807	Газрын төлбөр	0.81	0.66	3.13	2.94
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	3.77	3.37	0.44	0.36
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	-	0.66	0.66
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,744.21	3,940.51	4,980.39	4,814.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,988.33	3,179.86	4,097.22	3,933.54
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	755.88	760.65	883.17	880.86
212	ТАТААС	492.03	517.24	526.60	531.54
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	492.03	517.24	526.60	531.54
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	492.03	517.24	526.60	531.54
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,184.26	12,747.02	2,599.44	2,552.74
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	2,555.41	2,173.80	931.91	909.71
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	2,555.41	2,173.80	931.91	909.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,628.85	10,573.22	1,667.53	1,643.03
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	435.48	435.48	-	-
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	7,559.84	7,559.84	246.14	245.84
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	471.46	461.14	44.87	43.86
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	791.31	786.23	796.40	783.55
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	514.60	486.29	228.43	222.69
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	741.30	741.22	-	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	114.85	103.03	351.69	347.08
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,869.76	5,126.46	7,793.05	6,584.27
2200	Дотоод эх үүсвэрээр	7,869.76	5,126.46	7,793.05	6,584.27
220001	Барилга байгууламж	5,302.19	3,296.48	7,793.05	6,584.27
223001	Бусад хөрөнгө	2,567.57	1,829.98	-	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	73,918.49	70,444.43	79,352.74	75,544.61
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	39,966.28	39,879.45	40,768.31	40,590.79
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	39,966.28	39,879.45	40,768.31	40,590.79
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	27,889.19	27,739.68	32,941.88	33,051.68
132001	Орон нутгийн төсвөөс	24,093.47	23,943.96	26,456.00	26,759.30
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	3,795.71	3,795.71	6,485.88	6,292.37

БАЯНХОНГОР АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2019 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	-	-	486.42	375.93
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	6,063.02	2,825.31	5,642.55	1,902.14
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,612.72	1,839.68	2,024.85	1,355.63
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,469.31	985.63	732.43	546.52
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	1,980.99	-	2,885.27	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	1,657.59	0.00	2,593.86
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	2,593.86	0.00	1,977.08
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	236.00	236.00	236	236
610001	Төсвийн байгууллага	236	236	236	236
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	3,686.00	3,651.00	3,811	3,738
620001	Удирдах ажилтан	312	307	312	313
620002	Гүйцэтгэх ажилтан	2,249	2,249	2,257	2,220
620003	Үйлчлэх ажилтан	962	937	1,062	1,022
620004	Гэрээт ажилтан	163	158	180	183
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	21,291.00	21,335.00	16,785	16,575
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	16,236.00	16,617.00	16,785	16,575
630001	Төрийн өмчит ЕБС	16,236	16,617		
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	5,055.00	4,718.00		
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	5,055	4,718		
64	ЭМЧЛҮҮЛЭГСДИЙН ТОО	-	11,360.00	-	17,470
640001	Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо		2,824		2,622
640002	Улсын эмнэлгийн амбулатороор эмчлүүлэгсдийн тоо		8,536		14,848
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	3,686.00	3,651.00	3,811.00	3,738.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	335	323	337	338
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	3	4	3	4
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	1,496	1,449	1,514	1,488
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	132	157	143	153
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	284	278	287	261
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	1,085	1,085	1,180	1,143
650010	Гэрээт ажилтан	184	181	179	183
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	167	174	168	168

Эх сурвалж: Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайлан

29. Өмнөх оноос нийт төсвийн зардал 7029.0 сая төгрөгөөр өссөн нь Засгийн газрын шийдвэрээр цалин, томилолтын зардлыг нэмэгдүүлсэн, төсөвт байгууллагууд шинэ барилга ашиглалтад орсон зэргээс шалтгаалж, бараа үйлчилгээний зардал 15751.4 сая төгрөгөөр нэмэгдсэн, боловсролын салбарт ажиллагсдын төрөөс олгож байгаа тэтгэмж аймгийн Боловсрол, соёл урлагийн газраас олгож байгаагаас урсгал шилжүүлэг өмнөх оноос 10194.4 сая төгрөгөөр буурсан зэрэгтэй холбоотой байна.

Хүснэгт 11. Зардлын гүйцэтгэл /сая төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2018 он	2019 ОН	өмнөх оноос өөрчлөлт
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	69,508.1	76,537.1	7,029.0
УРСГАЛ ЗАРДАЛ	64,381.6	69,952.8	5,571.2
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	51,117.2	66,868.6	15,751.4
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	29,696.9	37,501.4	7,804.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,578.0	4,767.9	1,189.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,714.5	7,660.6	946.1
Хангамж, бараа материалын зардал	1,377.2	1,880.5	503.3
Норматив зардал	2,886.5	3,145.2	258.7
Эд хогшил, урсгал засварын зардал	652.9	2,641.9	1,989.0
Томилолт, зочны зардал	338.1	574.9	236.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,932.6	3,881.8	1,949.2
Бараа үйлчилгээний бусад зардал	3,940.5	4,814.4	873.9
ТАТААС	517.3	531.5	14.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,747.1	2,552.7	(10,194.4)
НИЙГМИЙН ХАМГААЛАЛ			-
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,126.5	6,584.3	1,457.8

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2018, 2019 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрснийг цаашид анхаарч, дүн шинжилгээ хийж ажиллах шаардлагатай байна. Үүнд:

Цалингийн зардал:

30. Цалингийн зардлыг анх 36825.5 сая төгрөгөөр баталж, төсөвт зохицуулалт хийж, зардлыг 133.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 37635.0 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 37501.5 сая төгрөгийг олгож, цалингийн зардлыг 133.5 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Оны эцэст цалингийн сан хүрэхгүйгээс хүсэлт тавьж төсвийг нэмж батлуулсан төсөв захирагч нар оны эцэст зардлыг зориулалтын дагуу зарцуулаагүй, хууль журмыг мөрдөж ажиллаагүй алдаа зөрчил төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайланд илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

- *Жинст, Эрдэнэцогт, Бууцагаан, Бөмбөгөр, Баянбулаг сумдын ерөнхий боловсролын сургууль, Бөмбөгөр сумын цэцэрлэг, Заг сумын Соёлын төв, Заг, Өлзийт сумын ЭМТ, ИТХ, Соёл, Бууцагаан сумын ЗДТГ, Баянхонгор сумын 15 дугаар цэцэрлэг, Галуут сумын цэцэрлэг, Бууцагаан сумын цэцэрлэг гэх мэт байгууллагууд цалингийн зардлын хэмнэлтээс түлш халаалтын хөнгөлөлтөд 59.0 сая төгрөгийг олгосон;*
- *Номундалай цогцолбор сургууль, 12-р цэцэрлэг, Заг, Баян-Овоо сумын эрүүл мэндийн төв, Бууцагаан, Жинст сумын цэцэрлэг зэрэг байгууллагууд цалингийн зардлаас ажиллагсдын нэмэгдэл цалин, шагналд 5.9 сая төгрөгийг илүү бодон олгосон;*
- *Жинст сумын сургууль 1.5 сая төгрөгийн үдийн цайны материал бэлтгэсэн;*
- *Баянхонгор сумын 10 дугаар цэцэрлэг, аймгийн ЗДТГ, Галуут сумын ЗДТГ, Бөмбөгөр, Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төв зэрэг байгууллагууд 9.4 сая төгрөгийн цалингийн урьдчилгаа олгоод цалингаас суутгаагүй;*
- *Жинст, Баянцагаан, Өлзийт, Баянлиг сумын ЕБС, аймгийн Хөгжимт драмын театр, Номгон ахлах сургууль зэрэг байгууллагууд сахилгын шийтгэлтэй ажилтнуудад 4.7 сая төгрөгийн урамшуулал олгосон;*
- *Баян-ойт, Баянлиг сумын сургуулиуд ажиллагсдад үр дүнгийн урамшууллыг улирлаар олгож байгаа атлаа жилээр үр дүнгийн урамшуулал бодсоноос нийт 9.7 сая төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна.*

- Цалингийн цэстийг тулган шалгахад ажиллагсдын цалингаас хуулиар суутгах суутгалаас гадна хамтын сан, фонд, хоол, хуримтлал, утасны төлбөр, хурим, хандивын суутгалыг суутгаж хоорондын тооцоо үүсгэдэг;
- Тэтгэвэрт гарсан тэтгэмжээ авсан ажилтнуудыг ажлаас чөлөөлж, дахин тушаал гарган ажиллуулахдаа хөдөлмөрийн гэрээгээр цалинг тогтоогоогүй, цалингийн шатлалаар цалинжуулж, нэмэгдэл хөлс олгосон;
- Тэтгэвэрт гарсан ажилтнуудын цалинг Нийгмийн даатгалын хэлтэст мэдээлдээгүй, мэдээлж байгаа зарим байгууллагууд ажилтныг 22 /тэтгэвэр тогтоолгосны дараа ажиллаж байгаа ажилтан/ кодоор мэдээлэхээр байхад 01 /Аж ахуйн нэгж байгууллагын ажилтан/ кодоор мэдээлснээс нийгмийн даатгалын санд даатгуулагч, ажил олгогчоос 6.8 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл илүү төлсөн;
- Шүүхийн шийдвэрээр албан тушаалд эгүүлэн томилогдсон албан хаагчдад олгох цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн нөхөн олгохдоо буруутай албан тушаалтнаар төлүүлээгүй, тайлант онд төсвөөс цалин, нэг удаагийн тэтгэмжийн зардлаас 74.8 сая төгрөгийг олгосон;
- Төсвийн мэргэжилтнүүд орон тооны төлөвлөгөөг төсвийн төлөвлөлтийн программд зөрүүтэй оруулсан, төсөвт байгууллагуудын нягтлан бодогч нар хэвтэн эмчлүүлэгсдийн тоо, суралцагсдын тоо, ажиллагсдын тоог оруулаагүй байхад түүнд төсвийн ерөнхий нягтлан бодогч хяналт тавьж ажиллаагүй байна.
- ИТХ-аас 17 сумын эрүүл мэндийн төвийн орон тоог 429-өөр баталсан байхад Эрүүл мэндийн газрын төсвийн мэргэжилтэн төсвийн төлөвлөлтийн программд 12-оор зөрүүтэй буюу 417 орон тоогоор оруулсан байна.

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал:

31. Төсөвт байгууллагуудын байр ашиглалттай холбоотой зардлыг анх 7782.7 сая төгрөгөөр баталж, жилийн явцад 16.5 сая төгрөгөөр бууруулж зохицуулалт хийж 7766.3 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 7660.6 сая төгрөг зарцуулж, зардлыг 105.7 сая төгрөгөөр хэмнэсэн нь дараах шалтгаантай байна.

Аудитын илрүүлэлт:

- Төсвийн мэргэжилтнүүд дараа жилийн төсвийн төслийг боловсруулахдаа халаалтын талбай, тариф, өмнөх оны өр, шинээр ашиглалтад орох барилгыг тооцоолж зардлыг төлөвлөөгүйгээс аймгийн Засаг даргын 2019.12.16-ний өдрийн А/645 тоот захирамжаар тусгай зориулалтын 19 байгууллагын халаалтын зардалд 181.0 сая, цэвэр бохир усны зардалд 10.4 сая, гэрэл цахилгааны зардалд 14.4 сая, нийт 205.8 сая төгрөгийг ангилагдаагүй зардлаас олгож, зардлыг тогтмол зардлаар тайлагнаагүй байгаа нь зардал зөв илэрхийлэгдээгүй зөрчил илэрсэн тул зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.
- Гурванбулаг сумын Соёлын төвийн биеийн тамирын арга зүйч 2019 оны 5 дугаар сараас эхлэн сумын ЗДТГ-ын багийн төвийн байранд иргэдэд үндэсний спортын клуб хичээллүүлж ажилласнаар тухайн байрны ашиглалтын зардлыг байгууллагын төсвөөс төлснөөс шалтгаалан түлш халаалтын зардлыг өмнөх оны гүйцэтгэлээс 11.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн зарцуулсан байна.

Иймд төсвийн мэргэжилтнүүд, төсвийн захирагч, нягтлан бодогч нарын ажлын хариуцлагыг сайжруулах, харилцаа уялдаатай ажиллахад анхаарч ажиллах шаардлагатай байна.

Үдийн цайны зардал:

32. Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн сурагчдад олгох үдийн цайны зардлыг өмнөх оноос 81.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж, анх 872.5 сая төгрөгөөр баталсныг оны дундуур аймгийн Засаг даргын захирамжаар төсөвт зохицуулалт хийж, 76.1 сая төгрөгөөр бууруулж, 796.4 сая төгрөгөөр баталж, хүүхэд өдрийн ирцийн зөрүүнээс зардлыг 12.8 сая төгрөгөөр хэмнэж, 783.6 сая төгрөг зарцуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

- *Жинст сумын Ерөнхий боловсролын сургууль үдийн цайны зардлын хэмнэлтийг оны эцэст төсөвт төвлөрүүлэлгүй, оны эцэст 1.5 сая төгрөгөөр хүнсний материал авч нөөцөлсөн байна.*

Хоолны зардал:

33. Аймгийн дүнгээр хоолны зардлыг анх 2730.9 сая төгрөгөөр батлагдсаныг 3219.6 488.7 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн бөгөөд гүйцэтгэлээр 3145.1 сая төгрөг зарцуулж, зардлыг 74.5 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- *Оны эцэст хоолны зардлын хэмнэлтээс 27 байгууллага 75.9 сая төгрөгийн хүнсний материал авч нөөцөлсөн байна.*

Томилолт, зочны зардал:

34. Томилолт, зочны зардлын 2018 оны гүйцэтгэл 338.1 сая төгрөг байсан ба тайланд онд тус зардлын бүлгийг 243.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 581.1 сая төгрөгөөр баталсныг оны дундуур төсөвт зохицуулалт хийж, 10.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, гүйцэтгэлээр 574.9 сая төгрөгөөр олгож, 16.2 сая төгрөгийн хэмнэлт гаргасан байна. Тайлант онд зочин төлөөлөгчийн зардлыг 14.0 сая төгрөгөөр хэтрүүлснийг дотоод томилолтын зардлын хэмнэлтээс гүйлгэн зарцуулжээ.

Хүснэгт 12. Томилолт зочны зардал / сая төгрөг/

Зардлын төрөл	2018 он				2019 он		
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Анх батлагдсан	Тодотгосон төсөв	Зохицуулалтын дүн	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
Гадаад томилолт албан	60.0	58.4	78.2	78.9	0.7	77.7	-1.2
Дотоод томилолт албан	263.3	256.9	384.3	388.8	4.5	359.7	-29.1
Зочин төлөөлөгч хүлээн авах	22.9	22.7	118.6	123.5	4.9	137.5	14.0
Дүн	346.2	338.1	581.1	591.1	10.0	574.9	-16.2

Эх сурвалж: Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

✚ Гадаад албан томилолтын зардлыг тайлант онд 1.2 сая төгрөгөөр хэмнэсэн бөгөөд гүйцэтгэлээр 77.7 сая төгрөг олгосноос 60.0 сая төгрөгийг аймгийн ИТХ-ын 41 төлөөлөгчдөд, 17.7 сая төгрөгийг сумын ЗДТГ, ИТХ-ын дарга, Баянхонгор сумын 6, 12 дугаар цэцэрлэгийн эрхлэгч нарт олгосон байна.

Аудитын илрүүлэлт:

Баян-Өндөр сумын ЗДТГ-ын төсвөөс 1.0 сая, Бууцагаан сумын ЗДТГ нь Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас 1.0 сая, аймгийн ЗДТГ 15.0 сая төгрөгийг гадаад томилолтын зардалд олгосон атлаа санхүүгийн тайланд зардлыг зөв тайлагнаагүй.

✚ Зочин төлөөлөгчийн зардлыг анх 118.6 сая төгрөгөөр баталсныг оны дундуур төсөвт зохицуулалт хийж, 4.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 123.4 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 137.4 сая төгрөг олгож, зардлыг 14.0 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

Зочин төлөөлөгчийн зардлыг Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан төсвийн зарлагын эдийн ангиллыг ашиглах зааврын 6 дугаар хавсралтад “Зочид төлөөлөгч хүлээн авах зардлыг гаднын зочид төлөөлөгч, тухайлбал Монгол улсад гадаад улсаас ирэх албан төлөөлөгч, гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газруудад Монгол улсын болон бусад орны албан төлөөлөгч айлчлахтай холбоотойгоор гарах зочид буудал, хоол, унаа, бэлэг дурсгалын зүйл олгох зардлыг энэ ангилалд тусгана” гэсэн заалтыг дагаж мөрдөлгүй хоол, хүнсний материал худалдан авахад тус зардлыг зарцуулсан Баян-Овоо, Баянбулаг, Бөмбөгөр сумдын ЗДТГ-т 10.4 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож,

Гурванбулаг, Жинст, Бөмбөгөр, Заг, Бууцагаан сум болон аймгийн ЗДТГ-т зөвлөмж хүргүүлсэн байна.

Хөрөнгийн зардал:

35. Тус зардлыг өмнөх оноос 2589.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж 7716.2 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 6584.3 сая төгрөгийн зардал олгож, 1208.7 сая төгрөгийн зардал хэмнэгдсэн байна.

✚ Сум хөгжүүлэх сангаас тайланд онд зээл олголтод 1514.7 сая, үйл ажиллагааны зардалд 21.5 сая төгрөг олгохоор батлагдсанаас 209 зээлдэгчид 1417.2 сая төгрөгийн зээл олгож, сангийн үйл ажиллагааны зардалд 18.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Аудитын илрүүлэлт

- *Зарим сум СХС-ийн эхний үлдэгдэлтэй, тайлант онд зээлийн эргэн төлөлтийн орлого орсон байхад хөнгөлөлттэй зээлийг сумын иргэдэд олгож, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжиж ажиллаагүй байна.*

Хүснэгт 13. Сум хөгжүүлэх сангийн мэдээлэл / сая төгрөг/

Д/Д	Сумын нэр	СХС-ын авлагын эхний үлдэгдэл	Оны эхний үлдэгдэл	Орлого					Зардал				Оны эцсийн үлдэгдэл			
				Сум хөгжүүлэх сангийн орлогын төлөвлөгөө	Зээлийн эргэн төлөлтийн орлого	Зээлийн хуугийн орлого	Бусад орлого	Нийт орлогын дүн	Төлөвлөгөө		2019 онд олгогдсон зээл			Сангийн үйл ажиллагааны зардалд зарцуулсан	Нийт зардлын дүн	
									Зээл олголт	Үйл ажиллагааны зардал	Төслийн тоо	Мөнгөн дүн				
1	Баянговь	101.1	89.2	34.2	23.1	0.0	0.7	57.9						1.1	1.1	146.0
2	Гурванбулаг СХСан	138.6	29.1	110.5	19.9	6.2	0.0	136.7						0.8	0.8	165.1
3	Заг	128.8	28.3	37.0	28.9	2.3	0.0	68.2						0.0	0.0	96.5
4	Шинэжинст	31.9	141.4	114.1	18.9	0.0	0.0	133.0			-	-		0.8	0.8	273.6
	Дүн	400.4	288.0	295.8	90.7	8.5	0.7	395.7	0.0	0.0	0.0	0.0	2.6	2.6	681.1	

Эх сурвалж: 2019 оны санхүүгийн тайлангийн аудит

Дээрх сумдын сум хөгжүүлэх сан оны эхэнд 288.0 сая төгрөгийн харилцах дансны үлдэгдэлтэй байхад сумд зээл олголтыг батлаагүй байгаа тул цаашид СХС-ийн дансны эхний үлдэгдэл, тухайн жилд төлөгдөх зээл, зээлийн хүүгийн орлогыг хугацаанд нь эргэн төлүүлж, сумын жижиг дунд үйлдвэрлэгч эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийг дэмжих, зээлийн эргэн төлөлтөд Сум хөгжүүлэх сангийн хяналтын зөвлөл хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

Орон нутгийн хөгжлийн сан:

Аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд 7635.0 сая төгрөгийн 307 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 267 төсөл арга хэмжээнд 3584.2 сая төгрөгийг зарцуулж, төлөвлөсөн төсөл арга хэмжээний 26 ажил огт хэрэгжээгүй, 14 ажил дутуу хэрэгжсэн байна.

Аудитын илрүүлэлт

- *Бөмбөгөр, Баянбулаг, Баянхонгор, Бууцагаан сумын ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэсэн 382.0 сая төгрөгийн хөрөнгийг хүлээн авсан авч ашиглаж байгаа атлаа санхүүгийн тайланд хөрөнгөөр бүртгээгүй байна.*
- *ОНХС-ийн төсвийг батлахдаа өмнөх оны үлдэгдлээс санхүүжих дүнг хянаагүйгээс Баян-Өндөр сум 11.8 сая, Баянбулаг сум 0.7 сая, Бууцагаан сум 1.8 сая төгрөгөөр оны эхний үлдэгдлээс зөрүүтэй баталж, Төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3⁵-т заасныг зөрчсөн байна.*

⁵ Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна”

Замын сан:

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2018.11.29-ны өдрийн 14/03 дугаар тогтоолоор АТБӨЯХАТ-ыг 426.0 сая, орон нутгийн авто зам ашигласны төлбөр 194.6 сая төгрөгөөр баталж, 2019.04.19-ний өдрийн 16/02 дугаар тогтоолоор өмнөх оны үлдэгдлээс 198.6 сая төгрөгөөр тодотгосон байна.

Аймгийн автозамын сангийн хөрөнгөөр 2019 онд өмнөх оноос шилжих 2 төсөл, арга хэмжээнд 85.5 сая, 2019 онд шинээр хэрэгжүүлэх 11 төсөл, арга хэмжээнд 620.6 сая, урьд оны төсвийн үлдэгдлээс 6 ажилд 198.6 сая төгрөг албан журмын даатгагчдын холбоонд 49.7 сая, автозамын тухай хуулийн 24.5-д заасан хяналтын зардалд 10.5 сая төгрөг олгохоор тус тус төлөвлөжээ.

Замын сангийн харилцах дансанд оны эхэнд 198.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа ба АТБӨЯХАТ-ын орлогоос 426.0 сая төгрөгийн санхүүжилт авч, авто зам ашигласны хураамжийн орлогоор 220.1 сая, нийт 667.0 сая төгрөгийн орлого төвлөрснөөс 19 батлагдсан төсөл, арга хэмжээнд 886.2 сая төгрөгийн зардал гаргаж 20.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Ангилалдаагүй зардал:

36. Аймгийн ИТХ-ын хуралдааны 2018.12.29-ний өдрийн 14/03 дугаар тогтоолоор ангилалдаагүй зардалд 24 хөтөлбөр, арга хэмжээнд 1756.9 сая төгрөг баталж, 2019.04.19-ний өдрийн 16/02 дугаар тогтоолоор оны эхний үлдэгдлээс 5 төсөл, арга хэмжээнд 255.6 сая, 2019.04.19-ний өдрийн 16/03 тогтоолоор утааг бууруулах ажлын хүрээнд цахилгаан халаагуураар иргэдийг хангах ажилд 100.0 сая, аймгийн Засаг даргын 2019.09.24-ны өдрийн А/489 дугаар захирамжаар 218.5 сая, 2019.12.16-ны өдрийн А/645 дугаар тогтоолоор 69.2 сая төгрөгийг нэмж төсөвт зохицуулалт хийж нийт 2400.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас, гүйцэтгэлээр 2398.0 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 2.7 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардалд анх 300.0 сая төгрөг батлагдаж аймгийн Засаг даргын 2019.12.16-ны өдрийн А/645 дугаар захирамжаар 0.3 сая төгрөг хасаж тодотгол хийж гүйцэтгэлээр 299.9 сая төгрөг зарцуулсан байна.

Гадаад арга хэмжээний зардалд анх 30.0 сая төгрөг батлагдаж, аймгийн засаг даргын 2019.09.24 А/489 дугаар захирамжаар 42.0 сая төгрөг нэмж тодотгосон ба 15 гадаад арга хэмжээний зардалд 72.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Аймгийн засаг даргын 2019.12.16-ны өдрийн А/645 дугаар захирамжаар төсөвт байгууллагуудын тогтмол зардалд 205.6 сая төгрөгийг нэмж тодотгон тус сангаас шууд харилцагч байгууллагуудын дансанд шилжүүлэн өрийг барагдуулсан.

Техник хяналтын барьцаа данс:

37. Техник хяналтын барьцаа дансанд 2209.2 сая төгрөгийн барилга байгууламжийн хяналтын барьцаа, дуусаагүй ажлын хяналтын барьцаа хөрөнгө орсон бөгөөд үүнээс тайлант онд 334.9 сая төгрөгийн зарцуулснаас 76.2 сая төгрөгийг гэрээний дагуу ГХБХБГ-т барилгын хяналтын зардал олгожээ.

Төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл 1601.8 сая төгрөг нь улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа төсөл, арга хэмжээнээс тооцсон барьцаа, 503.4 сая төгрөг нь ашиглалтад хүлээн авсан барилга байгууламжийн Барилгын тухай хуульд заасан баталгаат хугацааны барьцаа, 75.0 сая төгрөг нь

арилжааны банканд байршиж байгаа жижиг дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор байршуулсан мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байна.

Техник хяналтын барьцаа дансанд 714.5 сая төгрөгийн байгууллагаас авах авлага, 1554.4 сая төгрөгийн байгууллагад төлөх өглөг бүртгэлтэй байгаа нь улс, нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан барилгын ажлын чанарын баталгаа байна.

Тайлант онд барилгын техник хяналтаар ажилласан албан хаагчдын томилолт, шатахуун, барилгачдын зөвлөгөөн, мэргэшүүлэх сургалт зохион байгуулах, болон бусад зардалд 48.7 сая төгрөгийг зарцуулсан боловч анхан шатны баримт дутуу, томилолтоор ажиллах удирдамж, ажлын тайлан байхгүй, сургалт зохион байгуулах нэгдсэн удирдамж, төлөвлөгөөг гаргаагүй, оролцогчдын бүртгэл, үр дүнг илтгэсэн ажлын тайлан бичээгүй байгаа нь нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт сул байгаатай холбоотой байна. Тус данснаас 2019 онд 45.0 сая төгрөгийг тооцоо үүсгэж бусад байгууллагад олгосон атлаа тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Иймд техник хяналтын зардлыг холбогдох хууль, журмын дагуу зарцуулж, ажлын гүйцэтгэлийг тооцож, бусад байгууллагатай үүссэн авлагын тооцоог бүрэн барагдуулж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

БҮЛЭГ 3.

Аудитаар өгсөн зөвлөмжийг аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс биелүүлж ажиллахгүйгээс төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой зөрчлүүд давтагдан гарсаар байна.

38. Аймгийн ТЕЗ-ийн 2018 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга нарт 6 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлсэн боловч Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар”-ын 1.5.3-д “Дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн нь хяналтын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг удирдлагаар батлуулж, хэрэгжилтийг хангуулах, биелэлтийн нэгдсэн дүн, тайланг холбогдох байгууллагуудад хүргүүлэх” гэж заасныг хэрэгжүүлж төлөвлөгөө гаргаж ажиллаагүй байна.

39. “Аймгийн ТЕЗ-ийн эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэлийн 2019 оны эхний хагас жилийн тайланд хийсэн “Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц”- аудитаар 2018 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг 2019 оны 09 дүгээр сарын 13-ний байдлаар шалгахад 2 зөвлөмжийг бүрэн, 1 зөвлөмжийг дутуу хэрэгжүүлж, 3 зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс зөвлөмжийн биелэлт дунджаар 41.7 хувьтай дүгнэсэн ба тус аудитаар 5 байгууллагын удирдлагад нийт 15 зөвлөмж хүргүүлж ажилласан байна.

Хүснэгт 14. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт

№	Өгсөн зөвлөмж	Байгууллагаас ирүүлсэн албан бичгийн утга, биелэлт
Нэг. Аймгийн ИТХ-ын дарга Ц.Отгонбаяр		
1	Орон нутгийн өмчийн барилга байгууламжийг актлах, худалдах шийдвэр гаргахдаа хөрөнгийн хэрэгцээ шаардлага, төрийн байгууллагын үйл ажиллагаанд цаашид ашиглах боломжтой эсэхийг тооцож байх.	Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаж байна. Биелэлт 100%/

БАЯНХОНГОР АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2019 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

№	Өгсөн зөвлөмж	Байгууллагаас ирүүлсэн албан бичгийн утга, биелэлт
2	Худалдан борлуулсан хуучин барилга байгууламжийг төсвийн хөрөнгөөр өндөр үнээр буцаан худалдан авч, төсвийн үргүй зардал гаргадаг байдлыг зогсоох.	Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаж байна, 2019 онд ийм асуудал гараагүй гэсэн хариу ирүүлсэн. Биелэлт 100%
Хоёр. Аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагч Г.Батжаргал, аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга С.Байгалмаа нарт		
3	Төсвийн орлогын мэргэжилтэн төсвийн орлогыг нэмэгдүүлэх бааз суурийг өргөжүүлэх судалгааг хийж, холбогдох нотлох баримтыг албажуулж, орлогыг үндэслэлтэй төлөвлөж байх.	Холбогдох тооцоолол судалгаа хийж байгаа гэж хариу ирүүлж байгаа боловч бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, тооцоо судалгааг шат шатанд хянадаг механизм байхгүй байна. Биелэлт 80%
4	Төсвийн зарлагыг төлөвлөхдөө хууль тогтоомжийн хүрээнд холбогдох тооцоо, судалгаанд тулгуурлан, төсвийн хөрөнгийг үр ашигтай төлөвлөж, хэрэгжүүлж байх.	Оны эцэст аймгийн Засаг даргын шийдвэрээр төсөвт зохицуулалт хийсэн ба аймгийн төсвийн шууд захирагч нарын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн тоо өмнөх оноос өссөн, хэмнэгдсэн зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна. Биелэлт 50%
5	Сангийн яамны төсвийн төлөвлөлтийн програмд байгууллагуудын 2019 оны батлагдсан төсөв, эх үүсвэрийг зөрүүтэй оруулсан зөрчлийг 2019 оны 10 дугаар сард багтаан арилгах.	Сумдын тогтоолыг засч, төсвийн төлөвлөлтийн программд зөрүүтэй оруулсан орлогыг зассан гэж хариу ирүүлсэн боловч сумын ИТХ-ын тогтоолыг зардал, эх үүсвэрээр зөрүүтэй баталдаг, батлагдсан орлогын төлөвлөгөөг төсвийн төлөвлөлтийн программд зөрүүтэй оруулсан алдаа дахин давтагдсан байна. Биелэлт 30%
6	ТБОНӨХБАУХАТХ-ийн 5.1.15-д заасан зөвлөх үйлчилгээний ажлыг хэрэгжүүлэхдээ цаашид хуулийн 4 дүгээр бүлэгт заасан журмыг мөрдөж ажиллах.	Хэрэгжүүлж ажиллаж байна. Биелэлт 100%
7	Төсөвт байгууллагууд зардлын гүйцэтгэлийг эдийн засгийн ангиллын дагуу батлагдсан төсвийн хүрээнд "Засгийн газрын удирдлагын мэдээллийн систем"-д тусгагдсан төсвийн хэлбэлзэл, дансны хуулганы дүнтэй тохируулж, зөрчлийг арилган санхүүгийн тайлан, Шилэн дансны цахим хуудсанд үнэн зөв тайлагнаж байгаад аймгийн СТХС хяналт тавьж ажиллах.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аймгийн СТХС хяналт тавьж ажилласан. Биелэлт 100%
8	Аймгийн ЗДТГ-ын СТХС нь сумдын ИТХ-аар баталсан тогтоолд хяналт тавих, төсөвт байгууллага, ажиллагсдын тоо болон орлого, зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэлийг программд үнэн зөв оруулах, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасан бүрэлдэхүүн тус бүрээр төсвийн гүйцэтгэлийн тайланг гаргах, төсвийн орлого, зарлагын төлөвлөлт, гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж ажиллах зэрэг өмнөх аудитаар өгсөн зөрчлүүд арилахгүй байгаа тул холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцож, зөрчлийг бүрэн арилгах арга хэмжээ авч ажиллах.	Сумдын ИТХ-аар баталсан тогтоолыг хянаагүй, ажиллагсдын тоо, статистик мэдээг төсвийн гүйцэтгэлийн тайланд оруулаагүй, алдаа зөрчил гаргасан мэргэжилтнүүдэд хариуцлага тооцоогүй, Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу 2019 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг гаргаж ирүүлээгүй. Биелэлт 30%
9	Баян-Өндөр, Баянцагаан, Баянговь зэрэг зарим сумдад цагдаагийн хүү торгуулийн данс андуурч нээгдсэн асуудлыг холбогдох газарт тавьж шийдвэрлүүлэх.	Дансыг хаасан байна. Биелэлт 100%
10	Аймгийн ЗДТГ-ын орлогын мэргэжилтэн, аймгийн Татварын хэлтсийн орлогын эдийн засагч нарын ажлын уялдааг сайжруулж, татварын орлогын гүйцэтгэлийг үнэн зөв мэдээлж байгаад хяналт тавих.	Ажлын уялдааг сайжруулж ажиллаагүй, аудитаар аймгийн СТХС-ийн татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл аймгийн Татварын хэлтсээс ирүүлсэн дүнгээс зөрүүтэй байна. Биелэлт 30%
Гурав.Сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт		
11	Сангийн сайдын 2012 оны 244 тоот тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан загвар маягтын дагуу төсвийн төслийг өргөн мэдүүлж, төсвийн нийт эх үүсвэр, зардлыг хянаж, тооцооллын алдаагүй төсөв баталж байх.	Бүх сум батлагдсан маягтын дагуу тогтоолыг гаргаагүй, эх үүсвэр, зардлыг зөрүүтэй баталсан, тооцооллын алдаа хянаж ажиллаагүй байна. Биелэлт 50%
Дөрөв.Аймгийн Татварын хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч С.Рэнцэндагва танаа		
12	Аймгийн ЗДТГ-ын орлогын мэргэжилтэн, аймгийн Татварын хэлтсийн орлогын эдийн засагч нарын ажлын уялдааг сайжруулж, татварын орлогыг нэр заасан дансанд төвлөрүүлэх, гүйцэтгэлийг үнэн зөв мэдээлж байх.	Зөвлөмжийн дагуу ажиллаагүйгээс аймгийн СТХС, Татварын хэлтсийн мэргэжилтнүүдийн ажлын уялдаа хангалтгүй байна. Биелэлт 30%
13	Татварын орлогын гүйцэтгэлийг 2019 оны эхний хагас жилийн байдлаар төрийн сангийн дансны хуулганы дүнгээс зөрүүтэй тайлагнасан алдаа зөрчлийг 2019 оны 10 дугаар сарын 20-ны дотор арилгаж, жил бүр уг алдаа арилахгүй давтагдаж байгаад дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг авч ажиллах.	Алдаа зөрчлийг арилгасан гэх боловч орлогын нэр төрлөөр гүйцэтгэлийг зөрүүтэй тайлагнасан. Биелэлт 30%
Тав. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Ц.Идэрмөнх танаа		

14	Орон нутгийн өмч хөрөнгийг түрээслүүлэхдээ аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 43 тоот тогтоолоор баталсан түрээсийн төлбөрийн жишиг үнийг баримталж, тогтоолын 2.2 дахь заалтыг хэрэгжүүлж орон нутгийн өмчит болон төсөвт байгууллагуудтай хийсэн гэрээнд хяналт тавьж, шаардлагатай бол түрээсийн гэрээг шинэчлэх.	Аймгийн ОНӨГ, төсвийн байгууллага, харилцагч ААН, байгууллагын хооронд гурвалсан гэрээ байгуулж, зарим байгууллагын түрээсийн орлогыг аймгийн ИТХ-ын тогтоолын дагуу шинэчлэн ажилласан байна. Биелэлт 100%
15	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлогыг орон нутгийн төсөвт тухай бүр төвлөрүүлж байх.	Орлогыг тухай бүр төвлөрүүлж ажилласан. Биелэлт 100%

БИЕЛЭЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ 68.6%

Дээрх зөвлөмжийн биелэлтийг шалгахад 7 зөвлөмжийг бүрэн, 8 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, зөвлөмжийн биелэлт 68.6%-тай үнэлэгдэж байна. Аудитаар гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг өгсөн байхад зөрчил арилаагүй, давтагдаж байгаа тул аймгийн СТХС, ЭМГ-ийн төсвийн болон орлогын мэргэжилтний ажлын хариуцлагыг сайжруулж, түүнд тавих хяналтыг сайжруулах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Аймгийн ТЕЗ-ийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангаар дараах алдаа жил бүр давтагдан гарч байгаа нь аудитыг хуульд заасан хугацаанд гүйцэтгэхэд хүндрэл, бэрхшээлтэй байгаад цаашид анхаарч ажиллах шаардлагатай байна.

- ✚ Аймаг, сумын ИТХ-ын төсөв баталсан тогтоолын эх үүсвэр, зардлыг зөрүүтэй баталдаг;
- ✚ Аймгийн ЗДТГ-ын СТХС-ээс тогтоолыг хууль, журамд заасан хугацаанд хүлээн авч шалгаж хяналтыг хэрэгжүүлж ажилладаггүй;
- ✚ Аймаг, сумын тогтоолыг Сангийн яамны төсвийн төлөвлөлтийн программд зөрүүтэй оруулдаг;
- ✚ Аймгийн СТХС, ЭМГ-ийн төсвийн мэргэжилтнүүдийн зардлын төлөвлөсөн дүнг аймгийн дүнгээр ахлах мэргэжилтэн нэгтгэж гаргадаггүй, салбар хариуцсан мэргэжилтнүүдийн гаргаж ирүүлсэн мэдээг тайлан, хянах тогтолцоо байхгүйгээс аудитын явцад аймгийн дүнг нэгтгэж гаргаж байгаа нь цаг хугацаа их шаарддаг.
- ✚ Төсвийн төлөвлөлтийг өмнөх он, тайлант жилийн гүйцэтгэлтэй харьцуулсан дүн шинжилгээ хийдэггүй; гаргасан судалгаа, тайланг албажуулж ирүүлдэггүй, удаа дараа шаардуулдаг.

Аудитаар нийт 675.9 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 205.8 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага өгч, 470.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 10 зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэв.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Аймгийн орон нутгийн татварын орлогоор хог хаягдлын хураамжаас бусад нэр төрөл бүрээр давж биелүүлсэн байна.
2. Аймаг, сумдын ИТХ-аар 2019 оны төсвийг батлахдаа зарим сумын ИТХ төсвийн эх үүсвэр, зардлыг зөрүүтэй баталсан, аймгийн ИТХ-аар баталсан 132.3 сая, Жинст сумын ИТХ-аар баталсан 17.5 сая, Жаргалант сумын ИТХ-аар баталсан 1.0 сая төгрөгийн орлогыг Сангийн яамны төсвийн төлөвлөлтийн программд оруулаагүй орхигдуулсан байна.
3. Аймгийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн татварын орлогын төлөвлөгөө аймгийн Татварын хэлтсийн мэдээнээс 9.1 сая, гүйцэтгэл нь 204.5 сая төгрөгөөр зөрүүтэй байна.
4. Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн төсвийн мэргэжилтнүүд төсөвт байгууллагуудын зардлыг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс төсвийн жилийн дундуур төсөвт зохицуулалт хийж, шийдвэрийг зохицуулалт хийсний дараа нөхөн гаргасан байна.
5. Оны эцэст төсөвт байгууллагуудын хэмнэгдсэн зардалд зохицуулалт хийж, нэмж урсгал санхүүжилт олгож, төсвийг үр ашиггүй зарцуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна.
6. Зочин төлөөлөгчийн зардал, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын тогтмол зардлыг хөрөнгө бэлтгэх, сургалт, хүлээн авалт зохион байгуулах зэргээр зориулалт бусаар зарцуулж, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан төсвийн зарлагын эдийн ангиллыг ашиглах зааврын 6 дугаар хавсралтад заасны дагуу санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнаагүй байна.
7. Сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн орлогоор 763.0 сая төгрөг оруулж, төлөвлөснөөс 115.8 сая төгрөгийг дутуу оруулсан, өмнөх онуудын хугацаа хэтэрсэн зээлийн авлага төлөгдөхгүй байгаа гэсэн шалтгаанаар 4 сум 400.4 сая төгрөгийн харилцах дансны үлдэгдэлтэй байхад 2019 онд хөнгөлөлттэй зээлийг олгоогүй байна.
8. Төсөвт байгууллагууд ажиллагсдын цалингаас хоолны мөнгө, утасны төлбөр, хувцасны үнэ гэх мэт хуульд зааснаас бусад суутгалыг хийдэг, өндөр настны тэтгэвэрт гарсан ажилтнуудыг цалингийн шатлалаар цалинжуулж, тэдний нийгмийн даатгалын зардлыг буруу мэдээлснээс төсвөөс илүү зардал гаргасан байна.
9. Сумдын Соёлын төвүүдэд орон нутгийн төсвөөс суудлын автомашин олгож дэмжлэг үзүүлсэн байхад 2019 онд өөрийн орлогыг бүрдүүлэх талаар санаачилгагүй ажилласан, орлогыг төсөвт төвлөрүүлэхгүй зарцуулснаас 11 сумын Соёлын төв нэг ч төгрөгийн орлого оруулаагүй байна.
10. Техник хяналтын барьцаа данснаас барилгын техникийн хяналт хийхэд зарцуулж буй зардлын анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, түүнд тавих хяналт сул байна.
11. Төсвийн мэргэжилтнүүд орон тооны төлөвлөгөөг төсвийн төлөвлөлтийн программд зөрүүтэй оруулсан, төсөвт байгууллагуудын нягтлан бодогч нар хэвтэн эмчлүүлэгсэд, суралцагсад, ажиллагсдын тоог Э-тайланд оруулаагүй байхад хяналт тавьж ажиллаагүй байна.
12. Аудитаар өгсөн зөвлөмжийг аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс биелүүлж ажиллахгүйгээс төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой зөрчлүүд давтагдан гарсаар байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ



АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Нэг. Аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагч Г.Батжаргал, аймгийн ЗДТГ-ын СТХС-ийн дарга С.Байгалмаа нарт

1. Аймаг, сумдын ИТХ-аар баталсан тогтоолыг хянан хүлээн авч, Сангийн яамны төсвийн төлөвлөлтийн программд эх үүсвэр, зардлыг үнэн зөв оруулах.
2. Төсөвт байгууллагуудын төсвийн төсөлд тавих хяналтыг сайжруулж, төсвийн жилийн дундуур төсөвт зохицуулалт хийдэг, зохицуулалт хийсэн шийдвэрийг гүйлгээ гарсны дараа гаргадаг байдлыг таслан зогсоох.
3. Оны эцэст хэмнэгдсэн мөнгийг зориулалт бусаар зарцуулж, санхүүгийн тайланд авлагаар тусгадаг байдлыг давтан гаргахгүй байх.
4. Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан төсвийн зарлагын эдийн ангиллын дагуу санхүүгийн тайланд зардлыг зөв тайлагнах.
5. Сумын жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих зорилгоор хэрэгжүүлж байгаа Сум хөгжүүлэх сангийн зээлийн гэрээний биелэлтэд тавих хяналтыг сайжруулж, орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлж ажиллах.
6. Соёлын байгууллагуудын өөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлэхэд анхаарч, орлогыг харилцах дансанд төвлөрүүлэлгүй зарцуулж байгаад хяналт тавьж ажиллах.
7. Төсөвт байгууллагуудад өндөр настны тэтгэвэрт гарсан хүмүүсийн ажлыг Төрийн албаны зөвлөлөөс өгсөн зөвлөмжийн дагуу зохион байгуулж, нийгмийн даатгалын шимтгэлийг зөв мэдээлж, байгууллагын ажиллагсдын цалингаас Хөдөлмөрийн тухай хуульд заагдаагүй хоолны мөнгө, утасны төлбөр зэрэг бусад суутгалыг хийдэг байдлыг зогсоох.
8. Техник хяналтын барьцаа данснаас холбогдох хууль, журмын дагуу анхан шатны баримтад тулгуурлан зардлыг олгож, бусад байгууллагатай үүссэн авлагын тооцоог бүрэн барагдуулж ажиллах.
9. Төсөвт байгууллагын нягтлан бодогч нар Э-тайланд ажиллагсад, хэвтэн эмчлүүлэгсэд, суралцагсдын тоог үнэн зөв оруулж байгаад санхүүгийн албадын дарга нар хяналт тавьж ажиллах.

**Дөрөв.Аймгийн Татварын хэлтсийн даргын
үүрэг гүйцэтгэгч С.Рэнцэндагва танаа**

1. Сумын ИТХ-аар баталсан татварын орлогын төлөвлөгөөг татварын мэдээнд үнэн зөв мэдээлж, орлогын эдийн засагчийн ажлын хариуцлагыг сайжруулж, аймгийн нэгдсэн тайланд татварын орлогын гүйцэтгэлийг үнэн зөв мэдээлж байгаад хяналт тавьж ажиллах.

Зөвлөмжийн мөрөөр зохиосон ажил түүний хэрэгжилт үр дүнгийн тайланг, холбогдох баримтын хамт 2020 оны 12 дүгээр сарын 01-ны дотор хэрэгжсэн тухай бүрд нь Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ



Аймаг, нийслэлийн ИТХ-ын төлөөлөгчдөд олгосон тэтгэмж, урамшууллын судалгаа

/мянган төгрөгөөр/

Д/д	Аймгийн нэр	2019 онд олгосон												Нийт дүн		Тайлбар
		1		2		3		4		5		6				
		цалин		тэтгэмж		шагнал		урамшуулал		Тойрогт ажиллах зардал		Гадаад арга хэмжээний зардал		хүний тоо	мөнгөн дүн	
хүний тоо	мөнгөн дүн	хүний тоо	мөнгөн дүн	хүний тоо	мөнгөн дүн	хүний тоо	мөнгөн дүн	хүний тоо	мөнгөн дүн	хүний тоо	мөнгөн дүн	хүний тоо	мөнгөн дүн	хүний тоо	мөнгөн дүн	
3	Баянхонгор							10	10,800,000.00	41	123,000,000.00	41	60,000,000.00	92	193,800,000.00	1. Аймгийн ИТХ-ын 10 тэргүүлэгчид улиралд 270.0 мянга, жилд 10800.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон. 2. Жилд нэг төлөөлөгчид 3000.0 мянга, нийт 41 төлөөлөгчид 123000.0 мянган төгрөгийн тойрогт ажиллах зардал олгосон. 3. Нэг төлөөлөгчийн гадаад томилолын зардалд дунджаар 1463.4 мянган төгрөг олгож, 41 төлөөлөгчид 60000.0 мянган төгрөгийн гадаад томилолын зардал олгосон.
	Дүн	0	-	0	-	0	-	10	10,800,000.00	41	123,000,000.00	41	60,000,000.00	92	193,800,000.00	
	Нийт дүн	0	-	0	-	0	-	10	10,800,000.00	41	123,000,000.00	41	60,000,000.00	92	193,800,000.00	

Жич: Олгосон урамшууллыг ИТХ-ын тэргүүлэгчид, төлөөлөгчөөр салган тайлбарлах

Бэлтгэсэн: Ахлах аудитор *Б.Должмаа* Б.Должмаа

Аудитор *Н.Бүнчинсүрэн* Н.Бүнчинсүрэн

Хянасан: Аудитын менежер *А.Цэзням* А.Цэзням

Тэргүүлэх аудитор *Б.Мөнхбат* Б.Мөнхбат



Орон нутгийн ТЕЗ-ийн 2019 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

№	Аймгуудын нэр	Илэрсэн зөрчлийн утга	Зөрчлийн дүн		Үүнээс:							
			Тоо	Дүн	Зөвлөмж		Албан шаардлага		Төлбөрийн акт		Хууль хяналтын байгууллагад	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Баянхонгор	Сумдын ИТХ-ын төсөв баталсан тогтоолыг СТСХ-ийн мэргэжилтнүүд хянадаггүйгээс ИТХ-аар баталсан Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн өөрийн орлогыг 1.0 сая, Жинст сумын ОНХС-ийн орлогын 17.3 сая, хандив тусламжийн орлогын 12.2 сая, аймгийн ИТХ-аар баталсан ТЭЗҮ-ийн орлогын 132.3 сая төгрөгийн төлөвлөгөөг Сангийн яамны төсвийн төлөвлөлтийн программд оруулаагүй орхигдуулсан байна.	1	162,800.0	1	162,800.0						
2	Баянхонгор	Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн төсвийн мэргэжилтнүүд төсөвт байгууллагуудын зардлыг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс төсвийн жилийн дундуур төсөвт зохицуулалт хийж, шийдвэрийг зохицуулалт хийсний дараа нөхөн гаргасан байна.	1	-	1	-						
3	Баянхонгор	Техник хяналтын барьцаа данснаас барилгын техник хяналтаар ажилласан албан хаагчдын томилолт, шатахуун, барилгачдын зөвлөгөөн, мэргэшүүлэх сургалт зохион байгуулах, болон бусад зардалд анхан шатны баримт хангалтгүй байхад 48.7 сая төгрөгийн зардал гаргасан. Мөн тус данснаас 2019 онд 45.0 сая төгрөгийг тооцоо үүсгэж бусад байгууллагад олгосон атлаа тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	93,700.0	1	93,700						
4	Баянхонгор	Зочин төлөөлөгчийн зардал, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын тогтмол зардлыг хөрөнгө бэлтгэх, сургалт, хүлээн авалт зохион байгуулах зэргээр зориулалт бусаар зарцуулж, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан төсвийн зарлагын эдийн засгын ангиллыг ашиглах зааврын 6 дугаар хавсралтад заасны дагуу санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнаагүй байна	1	-	1	-						
5	Баянхонгор	Сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн орлогоор 763.0 сая төгрөг оруулж, төлөвлөснөөс 115.8 сая төгрөгийг дутуу оруулсан, өмнөх онуудын хугацаа хэтэрсэн зээлийн авлага төлөгдөхгүй байгаа гэсэн шалтгаанаар 4 сум 400.4 сая төгрөгийн харилцах дансны үлдэгдэлтэй байхад 2019 онд хөнгөлөлттэй зээлийг олгоогүй байна.Тайлант онд зээл, зээлийн эргэн төлөлтийн орлогоор оруулахаар төлөвлөсөн орлого тасарсан байна.	1	-	1	-						
6	Баянхонгор	Төсөвт байгууллагууд ажиллагсдын цалингаас хоолны мөнгө, утасны төлбөр, хувцасны үнэ гэх мэт хуульд зааснаас бусад суутгалыг хийдэг, өндөр настны тэтгэвэрт гарсан ажилтнуудыг цалингийн шатлалаар цалинжуулж, тэдний нийгмийн даатгалын зардлыг буруу мэдээлснээс төсвөөс илүү зардал гаргасан байна.	1	-	1	-						
7	Баянхонгор	Сумдын Соёлын төвүүдэд орон нутгийн төсвөөс суудлын автомашин олгож дэмжлэг үзүүлсэн байхад 2019 онд өөрийн орлогыг бүрдүүлэх талаар санаачилгагүй ажилласан, орлогыг төсөвт төвлөрүүлэхгүй зарцуулснаас 11 сумын Соёлын төв нэг ч төгрөгийн орлого оруулаагүй байна.	1	-	1	-						

№	Аймгуудын нэр	Илэрсэн зөрчлийн утга	Зөрчлийн дүн		Үүнээс:						
			Тоо	Дүн	Зөвлөмж		Албан шаардлага		Төлбөрийн акт		Хууль хяналтын байгууллагад
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
8	Баянхонгор	Төсвийн мэргэжилтнүүд орон тооны төлөвлөгөөг төсвийн төлөвлөлтийн програмд зөрүүтэй оруулсан, төсөвт байгууллагуудын нягтлан бодогч нар хэвтэн эмчлүүлэгсэд, суралцагсад, ажиллагсдын тоог Э-тайланд оруулаагүй байхад хяналт тавьж ажиллаагүй байна.	1	-	1	-					
9	Баянхонгор	Аудитаар өгсөн зөвлөмжийг аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс биелүүлж ажиллахгүйгээс төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой зөрчлүүд давтагдан гарсаар байна.	1	-		-	1	-			
10	Баянхонгор	Төсвийн мэргэжилтнүүд дараа жилийн төсвийн төслийг боловсруулахдаа халаалтын талбай, тариф, өмнөх оны өр, шинээр ашиглалтад орох барилгыг тооцоолж зардлыг төлөвлөөгүйгээс аймгийн Засаг даргын 2019.12.16-ний өдрийн А/645 тоот захирамжаар тусгай зориулалтын 19 байгууллагын халаалтын зардалд 181.0 сая, цэвэр бохир усны зардалд 10.4 сая, гэрэл цахилгааны зардалд 14.4 сая, нийт 205.8 сая төгрөгийг ангилагдаагүй зардлаас олгож, зардлыг тогтмол зардлаар тайлагнаагүй байгаа нь зардал зөв илэрхийлэгдээгүй байна.	1	205,800.0			1	205,800.0			
11	Баянхонгор	Аймгийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн татварын орлогын төлөвлөгөө аймгийн Татварын хэлтсийн мэдээнээс 9.1 сая, гүйцэтгэл нь 204.5 сая төгрөгөөр зөрүүтэй байна.	1	213,600.0	1	213,600.0					
12	Баянхонгор	Оны эцэст төсөвт байгууллагуудын хэмнэгдсэн зардалд зохицуулалт хийж, нэмж урсгал санхүүжилт олгож, төсвийг үр ашиггүй зарцуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна.	1	-	1	-					
Дүн			12	675,900.0	10	470,100.0	2	205,800.0	0	-	-

Жич: Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлангийн зөрчлийн нэгтгэлд орсон асуудлыг Төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн зөрчилтэй давхардуулаагүй болно.

Бэлтгэсэн: Ахлах аудитор

Аудитор

Хянасан: Аудитын менежер

Тэргүүлэх аудитор



Б.Должмаа

Н.Бүнчинсүрэн

А.Цээням

Б.Мөнхбат

Сум хөгжүүлэх сангийн зээлийн олголт, төлөлтийн судалгаа

/мянган төгрөг/

Д/д	Сумын нэр	Зээлийн эхний үлдэгдэл	2019 онд олгосон	2019 онд эргэн төлүүлэхээр			Нийт зээлийн эцсийн үлдэгдэл	Үүнээс: Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл	Нийт зээлийн дүнд хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувь	Тайлбар
				төлөвлөсөн	төлөгдсөн	төлөгдөөгүй				
1	Галуут СХСан	159,607.2	58,000.0	56,161.0	56,603.2	442.2	161,004.0	49,900.5	31.0	
2	Баян-овоо СХСан	88,272.8	112,920.0	85,978.5	21,274.6	64,703.9	179,918.2	57,578.2	32.0	
3	Эрдэнэцогт СХСан	129,701.8	57,000.0	50,426.6	60,176.5	9,749.9	126,525.3	54,597.3	43.2	
4	Бууцагаан СХСан	167,113.2	98,500.0	76,132.2	39,679.9	36,452.3	225,933.3	86,379.2	38.2	
5	Жинст СХСан	86,182.4	144,500.0	62,000.0	45,856.5	16,143.5	184,826.0	32,908.2	17.8	
6	Богд СХСан	173,941.2	67,000.0	78,500.0	64,843.6	13,656.4	176,097.6	18,241.4	10.4	
7	Баянлиг СХСан	133,412.9	88,000.0	52,965.2	40,513.4	12,451.8	180,899.4	71,053.2	39.3	
8	Баянговь СХСан	120,885.5	-	34,152.6	19,744.6	14,408.0	101,140.9	101,140.9	100.0	
9	Гурванбулаг СХСан	158,544.6	-	110,549.2	19,926.4	90,622.8	138,618.2	79,829.3	57.6	
10	Жаргалант СХСан	157,661.7	67,000.0	128,036.1	32,798.0	95,238.2	191,863.8	190,091.7	99.1	
11	Заг СХСан	156,998.4	-	40,000.0	28,118.9	11,881.1	128,879.6	36,147.4	28.0	
12	Баацагаан СХСан	188,998.9	108,000.0	160,900.0	53,885.1	107,014.9	243,113.9	91,855.5	37.8	
13	Бөмбөгөр СХСан	114,510.2	110,708.4	62,500.0	53,395.3	9,104.7	171,823.3	61,162.8	35.6	
14	Өлзийт СХСан	165,709.8	54,000.0	81,324.1	53,176.0	28,148.1	166,533.8	66,020.2	39.6	
15	Хүрээмарал СХСан	118,125.4	83,000.0	134,675.6	44,154.3	90,521.3	156,971.1	41,096.2	26.2	
16	Баянбулаг СХСан	138,136.9	60,000.0	30,341.7	45,350.6	15,008.9	152,786.3	79,212.0	51.8	
17	Шинэжинст СХСан	50,865.2	-	114,060.5	18,890.3	95,170.2	31,974.9	31,974.9	100.0	
18	Баянцагаан СХСан	228,628.2	40,000.0	106,000.0	115,566.2	9,566.2	153,062.0	153,062.0	100.0	
19	Баян-өндөр СХСан	174,390.0	51,800.0	102,800.0	73,090.0	29,710.0	153,100.0	27,960.0	18.3	
20	Баянхонгор СХСан	797,370.6	278,000.0	215,866.4	176,279.1	39,587.3	899,091.5	410,581.0	45.7	
	Баянхонгор аймгийн дүн	3,509,056.945	1,478,428.368	1,783,369.700	1,063,322.237	720,047.463	3,924,163.076	1,740,791.710	44.4	-

Бэлтгэсэн: Ахлах аудитор

Аудитор

Хянасан: Аудитын менежер

Тэргүүлэх аудитор

Б.Должмаа

Н.Бунчинсүрэн

А.Цээням

Б.Мөнхбат



Аймаг, нийслэлийн ИТХ-ын төлөөлөгчдөд олгосон тэтгэмж, урамшууллын судалгаа

/мянган төгрөгөөр/

Д/д	Аймгийн нэр	2019 онд олгосон												Нийт дүн		Тайлбар
		1		2		3		4		5		6				
		цалин		тэтгэмж		шагнал		урамшуулал		Тойрогт ажиллах зардал		Гадаад арга хэмжээний зардал		хүний тоо	мөнгөн дүн	
хүний тоо	мөнгөн дүн	хүний тоо	мөнгөн дүн	хүний тоо	мөнгөн дүн	хүний тоо	мөнгөн дүн	хүний тоо	мөнгөн дүн	хүний тоо	мөнгөн дүн	хүний тоо	мөнгөн дүн	хүний тоо	мөнгөн дүн	
3	Баянхонгор							10	10,800,000.00	41	123,000,000.00	41	60,000,000.00	92	193,800,000.00	1. Аймгийн ИТХ-ын 10 тэргүүлэгчид улиралд 270.0 мянга, жилд 10800.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон. 2. Жилд нэг төлөөлөгчид 3000.0 мянга, нийт 41 төлөөлөгчид 123000.0 мянган төгрөгийн тойрогт ажиллах зардал олгосон. 3. Нэг төлөөлөгчийн гадаад томилолын зардалд дунджаар 1463.4 мянган төгрөг олгож, 41 төлөөлөгчид 60000.0 мянган төгрөгийн гадаад томилолын зардал олгосон.
	Дүн	0	-	0	-	0	-	10	10,800,000.00	41	123,000,000.00	41	60,000,000.00	92	193,800,000.00	
	Нийт дүн	0	-	0	-	0	-	10	10,800,000.00	41	123,000,000.00	41	60,000,000.00	92	193,800,000.00	

Жич: Олгосон урамшууллыг ИТХ-ын тэргүүлэгчид, төлөөлөгчөөр салган тайлбарлах

Бэлтгэсэн: Ахлах аудитор *Б.Должмаа* Б.Должмаа

Аудитор *Н.Бүнчинсүрэн* Н.Бүнчинсүрэн

Хянасан: Аудитын менежер *А.Цэзням* А.Цэзням

Тэрдүүлэх аудитор *Б.Мөнхбат* Б.Мөнхбат



Орон нутгийн ТЕЗ-ийн 2019 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

№	Аймгуудын нэр	Илэрсэн зөрчлийн утга	Зөрчлийн дүн		Үүнээс:							
			Тоо	Дүн	Зөвлөмж		Албан шаардлага		Төлбөрийн акт		Хууль хяналтын байгууллагад	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Баянхонгор	Сумдын ИТХ-ын төсөв баталсан тогтоолыг СТСХ-ийн мэргэжилтнүүд хянадаггүйгээс ИТХ-аар баталсан Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн өөрийн орлогыг 1.0 сая, Жинст сумын ОНХС-ийн орлогын 17.3 сая, хандив тусламжийн орлогын 12.2 сая, аймгийн ИТХ-аар баталсан ТЭЗҮ-ийн орлогын 132.3 сая төгрөгийн төлөвлөгөөг Сангийн яамны төсвийн төлөвлөлтийн программд оруулаагүй орхигдуулсан байна.	1	162,800.0	1	162,800.0						
2	Баянхонгор	Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн төсвийн мэргэжилтнүүд төсөвт байгууллагуудын зардлыг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс төсвийн жилийн дундуур төсөвт зохицуулалт хийж, шийдвэрийг зохицуулалт хийсний дараа нөхөн гаргасан байна.	1	-	1	-						
3	Баянхонгор	Техник хяналтын барьцаа данснаас барилгын техник хяналтаар ажилласан албан хаагчдын томилолт, шатахуун, барилгачдын зөвлөгөөн, мэргэшүүлэх сургалт зохион байгуулах, болон бусад зардалд анхан шатны баримт хангалтгүй байхад 48.7 сая төгрөгийн зардал гаргасан. Мөн тус данснаас 2019 онд 45.0 сая төгрөгийг тооцоо үүсгэж бусад байгууллагад олгосон атлаа тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	93,700.0	1	93,700						
4	Баянхонгор	Зочин төлөөлөгчийн зардал, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын тогтмол зардлыг хөрөнгө бэлтгэх, сургалт, хүлээн авалт зохион байгуулах зэргээр зориулалт бусаар зарцуулж, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан төсвийн зарлагын эдийн засгын ангиллыг ашиглах зааврын 6 дугаар хавсралтад заасны дагуу санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнаагүй байна	1	-	1	-						
5	Баянхонгор	Сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн орлогоор 763.0 сая төгрөг оруулж, төлөвлөснөөс 115.8 сая төгрөгийг дутуу оруулсан, өмнөх онуудын хугацаа хэтэрсэн зээлийн авлага төлөгдөхгүй байгаа гэсэн шалтгаанаар 4 сум 400.4 сая төгрөгийн харилцах дансны үлдэгдэлтэй байхад 2019 онд хөнгөлөлттэй зээлийг олгоогүй байна.Тайлант онд зээл, зээлийн эргэн төлөлтийн орлогоор оруулахаар төлөвлөсөн орлого тасарсан байна.	1	-	1	-						
6	Баянхонгор	Төсөвт байгууллагууд ажиллагсдын цалингаас хоолны мөнгө, утасны төлбөр, хувцасны үнэ гэх мэт хуульд зааснаас бусад суутгалыг хийдэг, өндөр настны тэтгэвэрт гарсан ажилтнуудыг цалингийн шатлалаар цалинжуулж, тэдний нийгмийн даатгалын зардлыг буруу мэдээлснээс төсвөөс илүү зардал гаргасан байна.	1	-	1	-						
7	Баянхонгор	Сумдын Соёлын төвүүдэд орон нутгийн төсвөөс суудлын автомашин олгож дэмжлэг үзүүлсэн байхад 2019 онд өөрийн орлогыг бүрдүүлэх талаар санаачилгагүй ажилласан, орлогыг төсөвт төвлөрүүлэхгүй зарцуулснаас 11 сумын Соёлын төв нэг ч төгрөгийн орлого оруулаагүй байна.	1	-	1	-						

№	Аймгуудын нэр	Илэрсэн зөрчлийн утга	Зөрчлийн дүн		Үүнээс:						
			Тоо	Дүн	Зөвлөмж		Албан шаардлага		Төлбөрийн акт		Хууль хяналтын байгууллагад
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
8	Баянхонгор	Төсвийн мэргэжилтнүүд орон тооны төлөвлөгөөг төсвийн төлөвлөлтийн програмд зөрүүтэй оруулсан, төсөвт байгууллагуудын нягтлан бодогч нар хэвтэн эмчлүүлэгсэд, суралцагсад, ажиллагсдын тоог Э-тайланд оруулаагүй байхад хяналт тавьж ажиллаагүй байна.	1	-	1	-					
9	Баянхонгор	Аудитаар өгсөн зөвлөмжийг аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс биелүүлж ажиллахгүйгээс төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой зөрчлүүд давтагдан гарсаар байна.	1	-		-	1	-			
10	Баянхонгор	Төсвийн мэргэжилтнүүд дараа жилийн төсвийн төслийг боловсруулахдаа халаалтын талбай, тариф, өмнөх оны өр, шинээр ашиглалтад орох барилгыг тооцоолж зардлыг төлөвлөөгүйгээс аймгийн Засаг даргын 2019.12.16-ний өдрийн А/645 тоот захирамжаар тусгай зориулалтын 19 байгууллагын халаалтын зардалд 181.0 сая, цэвэр бохир усны зардалд 10.4 сая, гэрэл цахилгааны зардалд 14.4 сая, нийт 205.8 сая төгрөгийг ангилагдаагүй зардлаас олгож, зардлыг тогтмол зардлаар тайлагнаагүй байгаа нь зардал зөв илэрхийлэгдээгүй байна.	1	205,800.0			1	205,800.0			
11	Баянхонгор	Аймгийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн татварын орлогын төлөвлөгөө аймгийн Татварын хэлтсийн мэдээнээс 9.1 сая, гүйцэтгэл нь 204.5 сая төгрөгөөр зөрүүтэй байна.	1	213,600.0	1	213,600.0					
12	Баянхонгор	Оны эцэст төсөвт байгууллагуудын хэмнэгдсэн зардалд зохицуулалт хийж, нэмж урсгал санхүүжилт олгож, төсвийг үр ашиггүй зарцуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна.	1	-	1	-					
Дүн			12	675,900.0	10	470,100.0	2	205,800.0	0	-	-

Жич: Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлангийн зөрчлийн нэгтгэлд орсон асуудлыг Төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн зөрчилтэй давхардуулаагүй болно.

Бэлтгэсэн: Ахлах аудитор

Аудитор

Хянасан: Аудитын менежер

Тэргүүлэх аудитор



Б.Должмаа

Н.Бүнчинсүрэн

А.Цээням

Б.Мөнхбат

Сум хөгжүүлэх сангийн зээлийн олголт, төлөлтийн судалгаа

/мянган төгрөг/

Д/д	Сумын нэр	Зээлийн эхний үлдэгдэл	2019 онд олгосон	2019 онд эргэн төлүүлэхээр			Нийт зээлийн эцсийн үлдэгдэл	Үүнээс: Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл	Нийт зээлийн дүнд хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувь	Тайлбар
				төлөвлөсөн	төлөгдсөн	төлөгдөөгүй				
1	Галуут СХСан	159,607.2	58,000.0	56,161.0	56,603.2	442.2	161,004.0	49,900.5	31.0	
2	Баян-овоо СХСан	88,272.8	112,920.0	85,978.5	21,274.6	64,703.9	179,918.2	57,578.2	32.0	
3	Эрдэнэцогт СХСан	129,701.8	57,000.0	50,426.6	60,176.5	9,749.9	126,525.3	54,597.3	43.2	
4	Бууцагаан СХСан	167,113.2	98,500.0	76,132.2	39,679.9	36,452.3	225,933.3	86,379.2	38.2	
5	Жинст СХСан	86,182.4	144,500.0	62,000.0	45,856.5	16,143.5	184,826.0	32,908.2	17.8	
6	Богд СХСан	173,941.2	67,000.0	78,500.0	64,843.6	13,656.4	176,097.6	18,241.4	10.4	
7	Баянлиг СХСан	133,412.9	88,000.0	52,965.2	40,513.4	12,451.8	180,899.4	71,053.2	39.3	
8	Баянговь СХСан	120,885.5	-	34,152.6	19,744.6	14,408.0	101,140.9	101,140.9	100.0	
9	Гурванбулаг СХСан	158,544.6	-	110,549.2	19,926.4	90,622.8	138,618.2	79,829.3	57.6	
10	Жаргалант СХСан	157,661.7	67,000.0	128,036.1	32,798.0	95,238.2	191,863.8	190,091.7	99.1	
11	Заг СХСан	156,998.4	-	40,000.0	28,118.9	11,881.1	128,879.6	36,147.4	28.0	
12	Баацагаан СХСан	188,998.9	108,000.0	160,900.0	53,885.1	107,014.9	243,113.9	91,855.5	37.8	
13	Бөмбөгөр СХСан	114,510.2	110,708.4	62,500.0	53,395.3	9,104.7	171,823.3	61,162.8	35.6	
14	Өлзийт СХСан	165,709.8	54,000.0	81,324.1	53,176.0	28,148.1	166,533.8	66,020.2	39.6	
15	Хүрээмарал СХСан	118,125.4	83,000.0	134,675.6	44,154.3	90,521.3	156,971.1	41,096.2	26.2	
16	Баянбулаг СХСан	138,136.9	60,000.0	30,341.7	45,350.6	15,008.9	152,786.3	79,212.0	51.8	
17	Шинэжинст СХСан	50,865.2	-	114,060.5	18,890.3	95,170.2	31,974.9	31,974.9	100.0	
18	Баянцагаан СХСан	228,628.2	40,000.0	106,000.0	115,566.2	9,566.2	153,062.0	153,062.0	100.0	
19	Баян-өндөр СХСан	174,390.0	51,800.0	102,800.0	73,090.0	29,710.0	153,100.0	27,960.0	18.3	
20	Баянхонгор СХСан	797,370.6	278,000.0	215,866.4	176,279.1	39,587.3	899,091.5	410,581.0	45.7	
	Баянхонгор аймгийн дүн	3,509,056.945	1,478,428.368	1,783,369.700	1,063,322.237	720,047.463	3,924,163.076	1,740,791.710	44.4	-

Бэлтгэсэн: Ахлах аудитор

Аудитор

Хянасан: Аудитын менежер

Тэргүүлэх аудитор

Б.Должмаа

Н.Бунчинсүрэн

А.Цээням

Б.Мөнхбат



